



НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

/Судалгаа/

Глоб Интернэшнл төвөөс Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хэвлэл мэдээлэл ардчиллын төлөө” төслийн хүрээнд бэлтгэв.

Улаанбаатар хот

2019 он



Судлаачид:

- Глоб Интернэшнл төвийн тэргүүн Х.Наранжаргал
- Монголын Хуульчдын Холбооны гишүүн, хуульч Л.Галбаатар
- Глоб Интернэшнл төвийн хөтөлбөрийн менежер Ц.Мөнхжин

Агуулга

ӨМНӨТГӨЛ	3
УДИРТГАЛ	4
НЭГ. НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖООР ЗОХИЦУУЛЖ БУЙ БАЙДАЛ: БУСАД УЛСЫН ТУРШЛАГА	6
1.1. Судлах шаардлага: Монгол Улсын нөхцөл байдал	6
1.2. Онлайн агуулгыг (content) хуулиар зохицуулах чиглэл.....	9
1.3. Олон улсын хэм хэмжээ, зарчим.....	10
1.4. Батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж.....	16
1.4.1. ХБНГУ	16
1.4.2. Итали.....	18
1.4.3. Австрали	18
1.4.4. БНСУ.....	21
1.5. Гадаад улс, олон улсын байгууллагаас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.....	21
1.5.1. ИБУИНВУ	21
1.5.2. Европын холбоо.....	22
1.6.Фэйсбүүк компанийн бодлого, байр суурь	23
1.6.1. Монгол Улс ба Фэйсбүүкийн харилцаа	23
1.6.2. Интернетийг зохицуулах 4 чиглэл	24
1.7. Зарим орны засгийн газар, нам, эвслээс нийгмийн хэвлэл мэдээллийг хаах, түүнд тархи угаах үйл ажиллагаа явуулж буй байдал.....	24
ХОЁР. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ	26
2.1. Өөрийн зохицуулалтын хүрээ, ерөнхий чиглэл.....	26
2.1.1. TheAssociated Press(AP).....	26
2.1.2. BBC	28
2.1.3. The New York Times(The Times)	30
2.1.4. Asahi Shimbun.....	31
2.2. Хэвлэлийн зөвлөлийн үүрэг, оролцоо	31
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	34
3.1. Нийгмийн хэвлэл мэдээллийг хууль тогтоомжоор зохицуулж буй байдал	34
3.2. Нийгмийн сүлжээний орчин дахь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт	35
ЭХ СУРВАЛЖ	37

ӨМНӨТГӨЛ

Та бүхэнд нийгмийн хэвлэл мэдээллийн эрх зүйн болон өөрийн зохицуулалтад хийсэн судалгааны тайланг толилуулж байгаадаа таатай байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь улс төрийн нам байгуулах эрх, улс төрийн асуудлаар үзэл санаагаа хуваалцах эрх, төрийн албан тушаалтнуудын үйлдлийг хянан шалгах эрх гэх мэт ардчилсан бусад эрх чөлөөг бататган бэхжүүлэхэд шаардлагатай.

Уламжлалт, цахим, нийгмийн хэвлэл мэдээллийн агуулга нь иргэдийн хамтын эрхэд суурилсан олон нийтийн илэрхийллийг төлөөлж буй хэрэг юм. Ийм ч учраас иргэдийн санаа бодол, үзэл бодлоо хамгийн идэвхтэй илэрхийлэх талбар болсон нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалтын асуудал өнөөдөр тулгамдсан асуудлын нэг болжээ.

Иймд нийгмийн хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалтын шилдэг туршлагыг тодруулан судлах шаардлагатай байна. Эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ сүүлийн жилүүдэд хүрээгээ тэлж буйг энэ судалгаанаас харж болно. Нөгөөтэйгүүр, уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагууд цахим талбараа ашиглахдаа зохистой өөрийн зохицуулалт бий болгох, нийгмийн хэвлэл мэдээллийн сүлжээний талбар дахь хэт хөөрөгдөл, туйлшрал, хүчирхийлэл, үзэн ядалтыг дэвэргэсэн агуулгад хариу үйлдэл хийх чадавхтай болж, манлайллын үүрэг гүйцэтгэх ёстой. Энэ удаа бид гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагуудын өөрийн зохицуулалтын туршлагаас судлав.

Ардчилсан нийгмийн иргэд үзэл бодлоо илэрхийлэхдээ онцгой үүрэг хариуцлага хүлээнэ. Үндэснийхээ аюулгүй байдал, бусдын эрх, нэр хүндийг хамгаалах, нийгмийн зан суртахуун, дэг журмыг эрхэмлэх нь хүнээ дээдэлдэг ардчилсан нийгмийн үнэт зүйл юм.

Иймд эрүүл саруул нийгмийг цогцлоох, нийгмийн соёл, сэтгэл зүйг төлөвшүүлэхэд иргэд нь мэдээлэлтэй, эрх, эрх чөлөөнийхөө хязгаарыг мэддэг, ойлгодог байх нь чухал билээ. Эс бөгөөс эрх баригчид бидний язгуур эрх болох үг хэлэх, мэдээлэлтэй байх эрхийг хатуу боомилох болно.

Манай судалгааны тайлан та бидний хамтын ажил үйлст нэмэр болно гэдэгт найдаж байна.

Глоб Интернэшнл Төвийн тэргүүн Х.Наранжаргал

УДИРТГАЛ

Интернэт бидний өдөр тутмын амьдралд янз бүрийн үр нөлөө үзүүлэх болжээ. Нийгмийн сүлжээний хэрэглээ хурдацтай тархаж, Монгол Улсын хэмжээнд л гэхэд Фэйсбүүк платформын хэрэглэгчдийн тоо 2.1 саяыг даваад байгаа нь нэг талаар мэдээллийн урсгалыг урьд хожид байгаагүйгээр тэлж байна. Гэвч нөгөө талдаа хуулийн хүрээнд хамгаалагдсан аливаа хүний халдашгүй дархан байдал шууд халдсан, эсхүл үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хохирол учруулахуйц мэдээлэлд хяналт тавих боломж улам хумигдах болов. Өнөөгийн технологийн хөгжлийн хурдыг дагаж, хэвлэл мэдээллийн байгууллагууд ч нийгмийн сүлжээг ашиглах арга, барилаа сайжруулж, удирдамж, зарчмуудаа улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Нэн ялангуяа, мэдээллийн суурь боловсрол, мэдээлэлд шүүмжлэлтэй хандах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын талаарх мэдлэг ойлголт хангалттай бус, нийгмийн сэтгэл зүй зохих хэмжээнд төлөвшиж чадаагүй манай улсын хувьд анхан шатны судалгааны энэ тайлангийн үр дүн зайлшгүй стратеги, бодлого, төлөвлөлтөд хувь нэмэр болно гэдэгт найдаж байна.

Цахим орчин, ялангуяа нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалтын тухай ярихдаа, **нийгмийн сүлжээ** (social network) ба **нийгмийн хэвлэл мэдээлэл** (social media) гэсэн хоёр ойлголтыг нарийвчлах нь чухал юм. Монгол Улсад нийгмийн сүлжээ гэсэн нэр томъёог түлхүү хэрэглэдэг. Мөн социал ертөнц гэж бараг хэвшиж байна.

Англи хэлээрх мэдээллийн эх сурвалжуудад дээрх хоёр хэллэгийг хооронд нь хольж хэрэглэж болно гэж үзэх нь цөөнгүй ч тодорхой ойлголтын зөрүү байгаа гэж тайлбарлах нь ч бий.

Тухайлбал, нийгмийн хэвлэл мэдээлэл нь агуулгад төвлөрсөн бол нийгмийн сүлжээ нь харилцаанд илүүтэй тулгуурласан ойлголт гэж цахим орчны зарим мэргэжилтэн тайлбарлаж байна.¹ Өөрөөр хэлбэл, social media буюу нийгмийн хэвлэл мэдээллийг өргөн хүрээнд нэвтрүүлэх хэрэгсэл гэж хэлж болох бол social network буюу нийгмийн сүлжээ нь бусдыг хооронд нь холбоход ашиглагддаг хэрэгсэл юм. Энэ хоёр ойлголт нь утга зүйн талаас гадна хэрэглээний хувьд ч адилгүй.

Нийгмийн хэвлэл мэдээлэл нь өргөний хүрээний уншигч, үзэгч, сонсогчдод мэдээлэл түгээх, дамжуулахад голчлон төвлөрдөг. Харин нийгмийн сүлжээ нь ашиг сонирхол нэгтэй хүмүүсийг нэгтгэж, хүй олноор (community) дамжуулан харилцаа тогтооход үндэслэнэ. Нөгөөтэйгүүр, нийгмийн хэвлэл мэдээлэл нь харилцаа холбооны суваг бөгөөд домайн хаягаар дамжуулан зочилдог байршил биш юм. Харин эсрэгээрээ нийгмийн сүлжээ нь харилцан ярианд үндэслэн хөгждөг хоёр урсгалтай харилцаа билээ.²

¹ Huffington Post-ийн "Social Media vs. Social Networking" нийтлэл <https://www.huffpost.com/entry/social-media-vs-social-networking>

²The history of social media and its impact on business

https://www.researchgate.net/profile/Simeon-Edosomwan/publication/303216233_The_history_of_social_media_and_its_impact_on_business

Энгийнээр тайлбарлавал, **нийгмийн сүлжээ** нь танихгүй хүнтэй ч шууд харилцаа тогтоох боломжтой тодорхой цахим хуудсуудыг хэлж байна. Харин **нийгмийн хэвлэл мэдээлэл** нь дүрс бичлэг, дуу, зураг, нийтлэл гэх мэт агуулгыг нийгмийн сүлжээний хүрээнд түгээх систем юм. Энэ ч утгаараа нийгмийн хэвлэл мэдээллийн гол үнэ цэнэ нь бидний харилцаа, найз нөхөд, танилын сүлжээнд тулгуурладаг оршдог байна. Жишээлбэл, ямар ч дагагчгүй нийгмийн сүлжээний аккаунтаар хэчнээн сайн агуулга нийтэл, түгээхэд хэн ч харахгүй. Тиймээс нийгмийн хэвлэл мэдээллийг үнэ цэнэтэй байлгахын тулд эхлээд нийгмийн сүлжээгээ өргөтгөхөөс өөр замгүй юм.³

Канадын Шүүхийн Технологийн төв (СССТ)⁴-ийн тодорхойлолтоор “Нийгмийн хэвлэл мэдээлэл гэж цахим хуудаснаа орших, нийгмийн харилцан үйлчлэлийн анхдагч үнэт зүйлээс үүсэлтэй цахим хуудасны нэг төрөл” юм. Нийгмийн сүлжээ нь илүү өргөн хүрээтэй ойлголт ба үүнд цахим шуудангаас эхлэн Skype, Whatsapp, Viber гэх мэт онлайн арга хэрэгсэл багтдаг.

Интернэтийн эрх зүйг янз бүрийн хуулийн холимог гэж болно. Тухайлбал, зохиогчийн эрх хамгаалах, гэрээний тухай хуулиуд, хувийн нууц, халдашгүй дархан байдлыг хамгаалах, мөн ялгаварлан гадуурхах, хяхан хавчих, үзэн ядах үг хэллэгийг хориглох, хүчирхийлэл, дайн самууныг дэвэргэх, өөгшүүлэх зэрэг агуулга хязгаарлах ерөнхий хуулиуд ч онлайн орчинд үйлчлэх ёстойг НҮБ-аас удаа дараа анхааруулсан байдаг. Үүнээс гадна интернэтэд тусгайлан зориулагдсан өгөгдөл хамгаалах, кибер гэмт хэрэгтэй тэмцэх, кибер аюулгүй байдлыг хангах зэрэг хуулиуд ч байна.

Улс орнууд эрх зүйн зохицуулалтын зэрэгцээ хэвлэл мэдээлэл, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг нийгмийн хэвлэл мэдээллийн стратегитай болохыг дэмжиж байна. Нийгмийн хэвлэл мэдээллийн стратегид таван хүчин зүйл нөлөөтэй гэж үздэг. Үүнд:

1. Нийгмийн хэвлэл мэдээллийн бодлоготой байх
2. Зохистой тайлбар хийх
3. Ажилтнуудтайгаа хийх гэрээнд нийгмийн хэвлэл мэдээлэл ашиглах тухай заалт оруулах
4. Нийгмийн хэвлэл мэдээлэл ашиглахад учрах эрсдэлийн тухай ажилтнууддаа мэдлэг олгох
5. Байгууллагын тухай мэдээлэл, таних тэмдэг, логог хэрхэн ашиглаж буй, эсхүл тэдгээрийг урвуулан ашиглаж буй эсэхэд мониторинг хийх технологийн шийдэлтэй байх.

[its_impact_on_business/links/57fe90ef08ae56fae5f23f1d/The-history-of-social-media-and-its-impact-on-business.pdf](#)

³What's the difference between social media and new media <https://medium.com/@cspenn/whats-the-difference-between-social-media-and-new-media-71f7f5ae1eee>

⁴Canadian Centre for Court Technology. The Use of Social Media by Canadian Judicial Officers. May 2015 https://www.cacp.ca/law-amendments-committee-activities.html?asst_id=844

Энэ чиглэлээр манай улс ч бас идэвхийлэн ажиллаж байна. Гэсэн хэдий ч хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид нийгмийн хэвлэл мэдээллийн сувгуудыг чөлөөт илэрхийллийн талбарынх нь хувьд илүү ашиглаж, редакцын байр суурь, хувь сэтгүүлчийн илэрхийллийн хэм хэмжээ, зарчим, зааг ялгааг ухамсарлан ойлгоогүй хэвээр байна.

НЭГ. НИЙГМИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖООР ЗОХИЦУУЛЖ БУЙ БАЙДАЛ: БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

1.1. Судлах шаардлага: Монгол Улсын нөхцөл байдал

Монгол Улсад интернетийн хэрэглээ улам бүр нэмэгдсээр өдөр тутмын харилцаанд цахим мэдээллийн солилцоо эрчимтэй нэмэгдэв. Энэ нь үүрэн холбооны хэрэглэгч сард дунджаар 67 ширхэг SMS буюу гар утасны зурвас илгээж, ухаалаг утсаар интернет хэрэглэгчийн тоо 2,625,685-д, суурин интернет хэрэглэгчийн тоо 285,093-д хүрснээр илэрч байна.⁵



Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн судалгаагаар⁶ 2019 оны эхэн үеийн байдлаар уламжлалт мэдээллийн 348, мэдээллийн 109 сайт тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Мөн 92 сонины 56 хувь нь албан ёсны Фасебоок хаяг, хуудастай ажээ. 2018 оны Сэтгүүл зүйн ёс зүйн форумын үеэр Gogo.mn, Ikon.mn, Eagle TV зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагыг эс тооцвол дийлэнх нь цахим орчинд мөрдөх өөрийн зохицуулалтын ямар нэгэн удирдамж мөрдөөгүй байгаа тухай яригдсан.⁷


Нийгмийн санааг зовоож буй бас нэг зүйл гэвэл, цахим орчинд эрхээ хамгаалах мэдлэг, чадвар хангалтгүй хүмүүс цахим гэмт хэргийн хохирогч болох явдал нэмэгдсээр байна. Тодруулбал, цахим орчинд 1/ бусдыг доромжлох, 2/ гүтгэх, 3/ захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих, 4/ хувь хүний нууцыг задруулах, 5/ бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 6/ компьютерийн мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх, 7/ компьютерийн мэдээллийг хууль бусаар олж авах, 8/ компьютерийн мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэх, борлуулах, 9/ нянтай программ зохион бүтээх, ашиглах гэх мэт хэрэг үйлдэгдэж байна.

⁵Харилцаа холбооны зохицуулах хороо. Монгол Улсын харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд. 2017 он. <http://crc.gov.mn/k2Us>


⁶Хэвлэлийн хүрээлэн. "Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр", 2019.07.05 <https://ikon.mn/n/1m9r>

⁷Сэтгүүл зүйн ёс зүйн форум: Цахим орчинд хэвлэл мэдээлэл өөрийгөө зохицуулж буй сайн туршлагыг хэлэлцлээ. 2018.10.24 <https://ikon.mn/opinion/1ezp>

2014-2017 оны байдлаар цагдаагийн байгууллагад 331 цахим гэмт хэрэг бүртгэгдсэн байна.⁸ Энэ төрлийн гэмт хэргийн тоо 2017 оноос эрс нэмэгджээ. Энэ нь цахим хэрэглээ өсөх тутам цахим гэмт хэргийн хохирогч нэмэгдсээр байгааг харуулж байна.



Мөн 2014-2016 онд цахим орчинд гэмт хэргийн хохирогч болсон тухай нийт 476 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 202 гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.⁹



2018 онд Хэвлэл мэдээллийн зөвлөл, Дойчэ Вэллэ Академийн дэмжлэгтэйгээр Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвөөс “Цахим орчин дахь үзэн ядалтын үг хэллэг” судалгаа хийжээ. Судалгааны хүрээнд 2017-2018 онд олон нийтийн анхаарлыг татсан зарим үйл явдалд сэдэвчилсэн байдлаар, Фэйсбүүкийн хэрэглэгчдийн түгээсэн мэдээлэлд анализ хийхэд үзэн ядах үг хэллэг маш ихээр тархаж, цаашлаад үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэгт уриалан дуудах, өдөөн турхирах ноцтой үр дагавар бий болгох эрсдэлтэй байна. Хэрэглэгчид хэн нэгэн, эсхүл хэсэг бүлэг хүн рүү дайрч давшлах, хараалын үгээр залхаан цээрлүүлэх, гутаан доромжлохыг хэвийн үзэгдэл мэт хүлээж авах болсныг цуглуулсан жишээнүүд бэлхэн нотолж байна.¹⁰

Ийм байдал нь Монгол Улсын Их Хурлын зарим гишүүнээс “нийгмийн хэвлэл мэдээллийг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай” гэх мэт санал,

⁸ЦЕГ-аас ирүүлсэн статистикийн тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээ

⁹ Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016. Улаанбаатар. 2017 он. 229 дэх тал

¹⁰ #HateSpeech ба монголчууд. 2019.03.13 <http://eagle.mn/r/56970>

Хэвлэл мэдээллийн бодлого #2: Цахим мэдээллийн сайтууд дахь үзэн ядалтын үг хэллэг, 2018.09.25 <http://gogo.mn/r/230755>

санаачлага гаргахад хүргэх болсон. Тухайлбал, УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2019.04.23-ны өдрийн хуралдаанаар Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн. Энэ үеэр төсөлд нийгмийн сүлжээнд нэрээ нуусан хаягаас бусдын нэрээр орохыг болиулах, хориглох арга хэмжээ авах зорилгоор харилцаа холбооны үйлчлэгч нь хэрэглэгчийг регистрийн дугаараар нь бүртгэх, зах зээлд давамгайл хуулийн этгээд хамаарал бүхий этгээдэд хөнгөлөлттэй нөхцөлийг олгож, өрсөлдөөний тэгш бус байдал үүсгэж байгааг хязгаарлах зохицуулалтыг нэмж тусгажээ.¹¹ Харин энэ төсөл 2019.05.30-ны өдөр нийгмийн хэвлэл мэдээллийг цензурдах агуулгагүйгээр батлагдсан ч, хууль тогтоогчдын хүсэл зориг нийгмийн хэвлэл мэдээллийг хянахад чиглэж буйг харуулсан үйл явдал болсон юм.

Монгол Улсын харилцаа холбоо, нийгмийн хэвлэл мэдээлэлд учрах аюул заналыг судлаачид “улс төрийн тогтворгүй байдал”, “авлига”, “эрх зүйн орчны хоцрогдол”, “учирч болох эрсдэлийг бүрэн тооцоогүй”, “эсэргүүцэл, хүнд суртал” гэж тодорхойлжээ.¹²

Иймд бусад улсад нийгмийн хэвлэл мэдээллийг хууль тогтоомжоор хэрхэн зохицуулж буйг судлах замаар Монгол Улсад энэ талаарх эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт, шинэчлэлтэд анхаарах асуудлыг дэвшүүлэх, мөн нийгмийн хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг судлах замаар Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх шаардлага бий болоод байна.

¹¹ УИХ-ын Байнгын хороо: Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийв. 2019.04.23 <http://parliament.mn/n/4fco>

¹² Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Харилцаа холбооны зохицуулах хороо. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааны тайлан. 2017 он. 16 дахь тал <http://forum.parliament.mn/projects/458>

1.2. Онлайн агуулгыг (content) хуулиар зохицуулах чиглэл

Олон улсын туршлагаар цахим сүлжээн дэх хуулиар хориглосон агуулгыг хууль бус, хортой агуулгад хамруулдаг бөгөөд энэ нь дараах чиглэлтэй байна. Үүнд:¹³

- Үндэсний аюулгүй байдлыг хангах;

Жишээ нь, тэсрэх бөмбөг хийх заавар, хууль бус мансууруулах бүтээгдэхүүн, террорист үйл ажиллагаа бүхий агуулга нь хууль бус, хортой агуулга болно.

- Цөөнхийг хамгаалах;

Жишээ нь хүчирхийлэл, садар самуун, маркетингийн аливаа хэлбэрээр цөөнхийг доромжлох агуулга нь хууль бус, хортой агуулга болно.

- Хүүхдийг хамгаалах;

Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжил, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй агуулга нь хууль бус, хортой агуулгад хамаарна.

- Хүний эрхэм чанарыг хамгаалах;

Жишээ нь, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, үзэн ядах, түүнийг өдөөн турхирах агуулга нь хууль бус, хортой агуулга болно.

- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах;

Жишээ нь, залилан хийх, зээлийн картын мэдээллийг хулгайлах заавар бүхий агуулга нь хууль бус, хортой агуулга болно.

- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

Жишээ нь, мэдээлэл, түүний төхөөрөмжийг хорлон сүйтгэх агуулга нь хууль бус агуулга болно.

- Нууцлалын хамгаалалтыг бэхжүүлэх;

Жишээ нь, хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй дамжуулах, цахим харилцаагаар дамжуулан дарамтлах нь хууль бус болно.

- Нэр хүндийг хамгаалах;

Жишээ нь, гүтгэлэг, өрсөлдөгч бүтээгдэхүүнээ гутаах чиглэлийн хууль бус зар сурталчилгаа нь хууль бус болно.

- Оюуны өмчийг хамгаалах;

Жишээ нь, програм хангамж, хөгжим зэрэг зохиогчийн эрхийн бүтээлийг зөвшөөрөлгүйгээр түгээх нь хууль бус болно.

Эндээс харахад, нийгмийн хэвлэл мэдээллийг зохицуулах зорилго олон янз байх хэдий ч, гагцхүү хүний эрх, эрх чөлөө, бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэж байна.

¹³ How Countries Are Regulating Internet Content. Peng Hwa Ang /tphang@ntu.edu.sg/. Nanyang Technological University Singapore. https://www.isoc.org/inet97/proceedings/B1/B1_3.HTM

1.3. Олон улсын хэм хэмжээ, зарчим

2012 оны 6 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “Хүмүүсийн оффлайн орчин дахь эрхүүд, тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх эрх онлайн орчинд нэгэн адил хамгаалагдах ёстой” гэж тэмдэглэсэн. Мөн үүнийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2013 оны 11 дүгээр сард баталгаажуулж, хүмүүсийн оффлайн орчин дахь эрхүүд, тэр дундаа халдашгүй, нууцлалтай байх эрх онлайн орчинд нэгэн адил хамгаалагдах ёстой” гэж тэмдэглэсэн¹⁴. Тодруулбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2013 онд “Цахим орчинд халдашгүй байх эрхийг хэрэгжүүлэх” талаарх тогтоол баталж, түүгээр бүх улс орныг “...интернэтээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг эдэлж буй аливаа хүний цахим харилцаанд халдашгүй байх эрхийг хүндэтгэн хамгаалах, энэ эрхийг зөрчих явдлыг зогсоох шаардлагатай арга хэмжээ авах, дотоодын холбогдох хууль тогтоомжийг олон улсын хүний эрхийн гэрээний дагуу хүлээсэн үүрэгт нийцүүлэн уялдуулах, хэрэгжүүлэх зэргээр ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлэх”-ийг уриалсан нь интернэтэд үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг тусгайлан баталгаажуулсан олон улсын стандартад тооцогдож байна.¹⁵ Мөн 2015 оны 5 дугаар сард Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжих, хамгаалах асуудлаар НҮБ-ын Тусгай илтгэгч тайландаа цахим орчин дахь нэрээ нууцлах эрхийг НҮБ-ын гишүүн орнууд зөрчиж болохгүй гэдгийг онцгойлон анхааруулж, зөвлөсөн.¹⁶

ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгтэй холбоотой НҮБ-ын Хүний эрхийн хорооны тайлбарын 12, 15 болон 43-т вэб сайт, блог зэрэг интернэтэд суурилсан хэрэгсэл буюу цахим мэдээллийн сүлжээ нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг эдлэхэд чухал нөлөөтэй болохыг онцолсон байна. Мөн вэб сайт, мэдээлэл түгээх сүлжээгээр зөвхөн улс төр, нийгмийн систем, засгийн газрыг шүүмжилсэн материал нийтэлсний төлөө түүнийг хориглох нь ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хязгаарлалтын зохицуулалттай нийцэхгүй гэжээ.

Үүнээс гадна улс орнуудыг дэлхий даяарх харилцаа холбооны практикийг гайхалтай өөрчилсөн цахим хэлбэрээр мэдээлэл түгээх интернэт, хөдөлгөөнт холбоонд суурилсан сүлжээ гэх мэт мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжүүлэх ёстой гэжээ. Ингэхдээ интернэт, хөдөлгөөнт холбоо нь уламжлалт олон нийтийн мэдээллийн хэрэгслээс хэт хамааралгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хуваалцах эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд үйлчлэх дэлхий нийтийн сүлжээ болсныг хүлээн зөвшөөрч сайшаасан байна.

Иймд улс орнууд тэдгээр хэвлэл мэдээллийн шинэ хэрэгслийн хараат бус байдлыг хангах, хүн бүрт хүртээмжтэй болгоход шаардлагатай бүх арга хэмжээг авах нь зүйн хэрэг болжээ¹⁷.

¹⁴ Travel Guide to the Digital World: Surveillance and International Standards by Michael Karanicolas. London. 2014. p. 46

¹⁵ The Right to Privacy in the Digital Age <http://www.ohchr.org/EN/Issues/DigitalAge/Pages/DigitalAgeIndex.aspx> Resolution adopted by the General Assembly on 18 December 2013 68/167. The right to privacy in the digital age http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/68/167

¹⁶ Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, 22 May 2015. <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G15/095/85/PDF/G1509585.pdf?OpenElement>

¹⁷ UN Human Rights Committee's General Comment 34 on Article 19 of the International Covenant on Civil and Political Rights (ICCPR), p. 3, 4, 11 <http://www2.ohchr.org/english/bodies/hrc/docs/gc34.pdf>

Интернэтээр дамжуулан мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг баталгаатай эдлэх нь:

2016 оны “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр”-ийн хүрээнд НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу ЮНЕСКО-гоос интернэтэд хэвлэлийн эрх чөлөөг цагдан хянах, хэт мөрдөн тагнахаас хамгаалах асуудалд дэлхий нийтийн анхаарлыг хандуулсан.¹⁸ Ийнхүү интернэтэд цагдан хянах, хэт мөрдөн тагнахаас хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах замаар иргэдийн цахим орчинд мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг хамгаалах шаардлага нэмэгдэж байгааг олон улсын байгууллагууд, хүний эрхийн тусгай илтгэгчид анхааруулсан байдаг. Тухайлбал, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжих, хамгаалах асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгчийн 2015 оны тайланд “**сэтгүүлч, судлаач, хуульчид болон иргэний нийгмийн төлөөлөл мөрдөн тагналт, дарамтаас өөрсдийгөө, тэдгээрийн эх сурвалж, үйлчлүүлэгч, түншүүдээ хамгаалах зайлшгүй хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Тэдний хувьд энэ нөхцөл байдалд нэрээ нууцлах, мэдээллийн нууцлалыг хангах буюу шифрлэх боломжид найдах цаг болжээ**” гэж тэмдэглэсэн байна.¹⁹

Мөн үүнээс өмнө НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2013 онд “Цахим орчинд халдашгүй байх эрхийг хэрэгжүүлэх” талаар тогтоол баталж, түүгээр **бүх улс орныг “...Цахим харилцаанд халдашгүй байх эрхийг хүндэтгэн хамгаалах, энэ эрхийг зөрчих явдлыг зогсоох шаардлагатай арга хэмжээ авах, дотоодын холбогдох хууль тогтоомжийг олон улсын хүний эрхийн гэрээний дагуу хүлээсэн үүрэгт нийцүүлэн уялдуулах, хэрэгжүүлэх зэргээр ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлэх”-ийг уриалсан.**²⁰

Засгийн газар, зуучлагч байгууллагаас интернэтийн агуулгыг зохицуулах аргууд /вэб сайт, харилцааны хэрэгслийг хаах буюу блоклох/ нь олон улсын хэм хэмжээ буюу ИБУТЭОУП-ын 17 ба 19 дүгээр зүйлд заасан хэм хэмжээнд нийцэхгүй

¹⁸ Concept Note: Access to Information and Fundamental Freedoms This Is Your Right! World Press Freedom Day 3 May 2016 http://www.unesco.org/new/fileadmin/MULTIMEDIA/HQ/CI/CI/pdf/WPFD/WPFD2016_Concept-Note.pdf
Agenda, World Press Freedom Day in Helsinki on May 3rd 2016, Plenary 1: Protecting your rights: Surveillance Overreach, Data Protection, and Online Censorship. p.9
http://www.unesco.org/new/fileadmin/MULTIMEDIA/HQ/CI/CI/pdf/WPFD/Agenda_WPFD2016_Full_Online.pdf
Protecting Press Freedom from censorship and Surveillance Overreach. World Press Freedom Day-3 May. 2016.04.22 <https://www.facebook.com/notes/world-press-freedom-day-3-may/protecting-press-freedom-from-censorship-and-surveillance-overreach/1005552352813635>

¹⁹ 2015 Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression A/HRC/29/32
http://www.ohchr.org/EN/HRBodies/HRC/RegularSessions/Session29/Documents/A.HRC.29.32_AEV.doc.

²⁰ The Right to Privacy in the Digital Age <http://www.ohchr.org/EN/Issues/DigitalAge/Pages/DigitalAgeIndex.aspx>
Resolution adopted by the General Assembly on 18 December 2013 68/167. The right to privacy in the digital age http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/68/167

байна.²¹ Энэ нь “зуучлагч байгууллага” буюу техникийн байгууллага нь агуулгыг нийтлэхээс өмнөх шатанд агуулгыг хууль ёсоор хариуцаж байгаатай холбоотой байна.

Хувь хүмүүсийг интернэтэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөгөө эдэлсний төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь хүний эрхийн зөрчилд хүргэсээр байна. Хүний эрх, эрх чөлөөний асуудлаарх олон улсын байгууллагууд гүтгэлгийн эрх зүйн асуудал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах нөхцөл болохгүй байх, үүний тулд гүтгэлгийг гэмт хэрэгт тооцохгүйгээр иргэний эрх зүйн зөрчилд хамааруулахыг уриалсан байдаг.²²

Хакердах үйлдэл бүхий програм хангамжийг импортлох, кибер халдлага үйлдэх замаар хэт мөрдөн тагнах нь цахим орчин дахь хууль ёсны хэвлэлийн эрх чөлөөнд заналхийлж буй өөр нэг аюул болж байна. Цахим харилцаа, и-мэйл дэх шифрлэлт нь террорист халдлагатай холбоотой эсэх талаар засгийн газрын байгууллагууд маргах болж, өөрсдийн үйл ажиллагааг зөвтгөхийг оролдох болов.

Хэт мөрдөн тагнах нь нууцын болон бусад хууль тогтоомжоор нээлттэй, ил тод байдлыг хязгаарлах, улмаар мөрдөн тагнах ажиллагааны “хангалттай үндэслэлтэй”, “зохих хэмжээнд” байх олон улсын стандартыг хэтрүүлэх замаар хэрэгжиж байна.²³ Энэ нь ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний дотор мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг хуулиар хязгаарлах агуулгыг “хангалттай үндэслэлгүй”, “зохих хэм хэмжээ агуулаагүй” ямар нэг хуулийн тухай санаа мэт тайлбарлах нь зохимжгүй юм.²⁴

Өнөө цагт цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, халдашгүй байх эрхийн баталгаа нь нэрээ нууцлах болон шифр ашиглахтай салшгүй холбоотой болж байна. Халдашгүй байх буюу нууцлах эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэх болон сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах урьдчилсан нөхцөл мөн.

²¹17 дугаар зүйл

1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.
2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

19 дүгээр зүйл

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:
 - а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
 - б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

²² Joint Declarations of the representatives of intergovernmental bodies to protect free media and expression. Ed. by Adeline Hulin. - Vienna: OSCE Representative on Freedom of the Media, 2013. p.22-23.

<http://www.osce.org/fom/99558?download=true>

²³ Protecting Press Freedom from censorship and Surveillance Overreach. World Press Freedom Day-3 May. 2016.04.22 <https://www.facebook.com/notes/world-press-freedom-day-3-may/protecting-press-freedom-from-censorship-and-surveillance-overreach/1005552352813635>

²⁴ Necessary and Proportionate: International Principles on the Application of Human Rights to Communications Surveillance with Background and Supporting International Legal Analysis. Published by the Electronic Frontier Foundation. 2015

“Хил Хязгааргүй Сурвалжлагчид” байгууллагаас 2019 онд гаргасан 180 улсын сэтгүүлчдийн эрх чөлөөний байдлыг хэмждэг “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд 2019 онд Монгол Улс 29.51 гэсэн үзүүлэлтээр 70-р байранд орж “Хэвлэлийн эрх чөлөө мэдэгдэхүйц асуудалтай” гэж үнэлэгдсэн байна.²⁵ Үүнд цахим орчны хэвлэл мэдээллийн эсрэг шүүхийн хэрэг нэмэгдсэн, вэб сайтуудыг хаах/блоклох нь эрчимтэй нэмэгдсэн зэрэг нөлөөлжээ²⁶.

ИБУТЭОУП-ын 17 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Мөн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”, 2 дахь хэсэгт “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”, 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж заасан.²⁷

Эндээс хэвлэлийн эрх чөлөөг цагдан хянах, хэт мөрдөн тагнахаас хамгаалахтай холбоотой дараах асуудал тулгарч байна. Үүнд:

- Хаалт хийх, шүүлтүүр хэрэглэх, мөрдөн тагнах явдлыг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах олон улсын хууль ёсны стандартыг хангаж байгаа эсэхийг хэрхэн баталгаажуулах вэ? Эдгээр арга, хэрэгслийг олон улсын стандартад нийцэж байгаа эсэхийг хэрхэн таних вэ?
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд харшилсан арга, хэрэгслийн эсрэг ямар хамгаалалт байдаг вэ? зөрчлөөс урьдчилан сэргийлэх ямар арга зам байна вэ?
- Өгөгдөл хамгаалах, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах, нэр ашиглахгүй байх, шифрлэх нь цахим орчинд хэвлэлийн эрх чөлөөг хэрхэн дэмжих вэ?

Дээрх нөхцөл байдал нь цахим орчинд “Хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл авах эрх, ил тод байдлыг хангах” болон “Нууцлал, өгөгдөл хамгаалах” асуудлын тэнцвэрийг хангах ёстойг харуулж байна. Энэ тэнцвэрийг хангахын тулд ЮНЕСКО-гийн боловсруулсан цахим орчинд мэдлэг олгох, тогтвортой хөгжлийг хангах зарчмыг баримтлах нь зүйтэй юм.²⁸ Энэ зарчим нь Хүний эрхэд суурилсан, Олон талын

²⁵ 2019 World Press Freedom Index by Reporters Without Borders, <https://rsf.org/en/mongolia>

²⁶ Энэ индексийг тухайн улсын дараах үзүүлэлтийг ашиглаж гаргадаг: олон ургалч үзэл, хэвлэл мэдээллийн хараат бус байдал, өөрийн цензур, эрх зүйн орчин, ил тод байдал, дэд бүтэц, зөрчил.

²⁷ International Covenant on Civil and Political Rights /Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2200A (XXI) of 16 December 1966 entry into force 23 March 1976, in accordance with Article 49/ <http://www.ohchr.org/en/professionalinterest/pages/ccpr.aspx>

²⁸ “ROAM”: human Rights, Openness, Accessibility and Multi-stakeholder participation.

оролцоог хангасан байх, Нээлттэй байдлыг хангасан, Хүртээмжтэй байх буюу “ХОНХ” гэгдэх зарчим юм.

Мөн дээр дурдсан зарчмыг баримтлах, хэрэгжүүлэхийн зэрэгцээ “Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд хүний эрхийн олон улсын зарчмыг баримтлах талаарх бүх нийтээр хэрэгжүүлэх удирдамж”-ийг дагаж мөрдөх нь зүйтэй юм.²⁹ “Харилцаа холбоог мөрдөн тагнах” гэдэг нь зөвхөн хувийн мэдээллийг өөр этгээд уншихаар хязгаарлагдахгүй бөгөөд бүрэн хэмжээний мониторинг, мэдээллийг дундаас нь олж авах, цуглуулах, дүн шинжилгээ хийх, ашиглах, хадгалах, хөндлөнгөөс оролцох, тухайн этгээдийн өнгөрсөн, одоо, ирээдүйг тодорхойлох буюу түүнд нөлөөлөх мэдээлэл олж авах, хандах үйлдлийг ойлгодог. Энэ нь зарим засгийн газрын тайлбарладаг “автоматаар буюу хүний оролцоогүйгээр, компьютероор мэдээлэл цуглуулах, мониторинг хийх нь мөрдөн тагналт болохгүй” гэснийг олон улсын эрх зүйн үүднээс үгүйсгэж байгаа юм.³⁰

Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд баримтлах хүний эрхийн олон улсын зарчмууд		
№	Зарчмын нэр	Товч утга
1	Хууль зүйн үндэслэлтэй байх	Хувийн нууцтай байх эрхийн аливаа хязгаарлалтыг хуулиар урьдчилан тогтоосон байх ёстой.
2	Хууль ёсны зорилготой байх	Ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай эрх зүйн тэргүүлэх зэргийн ашиг сонирхолд нийцэхүйц хууль ёсны зорилгод хүрэхийн тулд төрийн эрх бүхий байгууллагаас харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахыг гагцхүү хуулиар зөвшөөрнө.
3	Шаардлагатай байх	Улс оронд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн хууль тогтоомж нь хууль ёсны зорилгод тодорхой, үр дүнтэй хүрэхийн тулд маш нарийн тодорхойлсон, зайлшгүй шаардлагатай хэмжээгээр л мөрдөн тагнах ажиллагааг хязгаарлавал зохино.
4	Нийцэхүйц байх	Хуулиар тогтоосон харилцаа холбоог мөрдөн тагнах аливаа ажиллагаа нь тодорхой тогтоосон хууль ёсны зорилгыг бүрэн биелүүлэхэд нийцсэн байвал зохино.
5	Дүйцэхүйц байх	Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаа явуулах тухай шийдвэрт нэвтэрсэн мэдээллийн эмзэг мэдрэмжтэй байдал хийгээд хүний эрхийн болон бусад янз бүрийн эрх ашгийг зөрчих эрсдэлийг харгалзах ёстой.
6	Эрх мэдэл бүхий шүүхийн байгууллага	Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаатай холбогдох шийдвэрийг эрх бүхий шүүх эрх мэдлийн хараат бус, шударга байгууллага гаргах ёстой.
7	Зохих ёсны ажиллагаа	Улс орнуудаас хүний эрхэд халдсан аливаа хууль ёсны үйл ажиллагааг хуульд сайтар зүйлчилж, тогтвортойгоор дагаж мөрдөн, олон нийтэд нээлттэй байдлыг хангаснаар хүний эрхийг хүндэтгэн сахин хамгаалахыг шаардана.
8	Хэрэглэгчдэд мэдэгдэл өгөх	Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд өртөж буй хувь этгээдэд харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг зөвшөөрсөн шийдвэрийн талаар давж заалдах гомдол гаргах, эрх зүйн бусад өмгөөлөл эрэлхийлэхэд хангалттай байхуйц хугацаанд мэдэгдэх шаардлагатай.

“Keystones to foster inclusive Knowledge Societies: Access to information and knowledge, Freedom of Expression, Privacy, and Ethics on a Global Internet”. Final study. Published in 2015 by the United Nations Educational, Scientific and Cultural Organization 7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France p.17

<http://unesdoc.unesco.org/images/0023/002325/232563E.pdf>

²⁹Universal Implementation Guide for the International Principles on the Application of Human Rights to Communications Surveillance. A Product of ACCESS. May 2015. Accessnow.org

https://en.necessaryandproportionate.org/files/2016/04/01/implementation_guide_international_principles_2015.pdf

Access байгууллагаас эрхлэн гаргасан “Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд хүний эрхийн олон улсын зарчмыг баримтлах талаарх бүх нийтээр хэрэгжүүлэх удирдамж”-ийн монгол хэл дээрх орчуулгыг Глоб интернэшнл төвийн цахим хуудсаас бүтнээр нь үзэх боломжтой.

<http://globeinter.org.mn/images/upld/universalimplementationguidebyaccessmon.pdf>

³⁰ Necessary and Proportionate: International Principles on the Application of Human Rights to Communications Surveillance with Background and Supporting International Legal Analysis. Published by the Electronic Frontier Foundation. 2015. p.21-22

9	Ил тод байдал	Улс орнууд харилцаа холбоог мөрдөн тагнах тухай хуулийн хамрах хүрээ болон хэрэглээ, журам, үйл ажиллагаа, эрх мэдэл буюу эрх бүхий байгууллагын асуудлаар ил тод байх үүрэгтэй.
10	Олон нийтийн хяналт	Улс орнууд нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор хяналтын хараат бус механизм бий болгох шаардлагатай.
11	Харилцаа холбоо, сүлжээний халдашгүй бүрэн бүтэн байдал	Улс орнууд нь үйлчилгээ үзүүлэгчид, техникийн болон программ хангамжийн борлуулагчдыг сүлжээндээ мөрдөн тагнах ажиллагаа буюу мониторинг хийх чадавхийг бий болгох, эсвэл төрийн харилцаа холбоог мөрдөн тагнах зорилгоор тодорхой мэдээллийг цуглуулах, хадгалахыг албадах ёсгүй.
12	Олон улсын хамтын ажиллагааны баталгаа	Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ болон улс орнуудын байгуулж буй бусад гэрээ хэлэлцээрүүд нь нэгээс дээш улсын хууль тогтоомж нь харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд нийцэх, хувь хүмүүст өндөр хэмжээний хамгаалалт өгсөн мөрдөгдөж буй хэм хэмжээг ашиглавал зохино.
13	Хууль бус хандалтын эсрэг баталгаа ба эрх зүйн үр нөлөөтэй хамгаалалт авах эрх	Улс орнууд төрийн болон хувь этгээдийн зүгээс хууль бусаар харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагааг гэмт хэрэгт тооцсон хууль тогтоомжтой болсон байх үүрэгтэй.

Энд дурдсан харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд баримтлах хүний эрхийн олон улсын зарчмуудтай адил агуулга бүхий нээлттэй захидлыг 42 орны 200 гаруй мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн, сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөний идэвхтнүүд Дэлхийн төр, засгийн тэргүүн нарт хандан 2016 оны нэгдүгээр сард бичсэн юм. Энэ захидалд цахим эрин дэх Үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөг эдлэхэд зайлшгүй шаардлагатай хувийн нууц, аюулгүй байдлын хамгаалалт буюу шифрлэлтийн эсрэг явуулж буй төрийн байгууллагуудын үйл ажиллагааг шүүмжилжээ.³¹ Энэ захидалд дараах асуудлыг хөндсөн байна. Үүнд:

- Төр, засгаас хэрэглэгчийн аливаа төрлийн шифрт хандах хандалтыг хаах, хязгаарлах, мөн шифрийг ангилал, төрөл хэлбэрийн дагуу боловсруулан гүйцэтгэх, ашиглахыг хориглох ёсгүй;
- Төр, засгаас тоног төхөөрөмж, технологи, үйлчилгээнд зөвшөөрөлгүй хандах техникийн шийдэл бүтээх, түүнийг гүйцэтгэх, мөн түүнчлэн эмзэг сул байдал үүсгэхүйц шийдвэр гаргах ёсгүй;
- Төр, засгаас гуравдагч этгээдийн хандалтаас шифрлээгүй өгөгдөлд халдах, шифрийн түлхүүр тайлах тоног төхөөрөмж, технологи, үйлчилгээг бий болгох, дэлгэрүүлэхийг шаардах ёсгүй;
- Төр, засгаас шифрлэх хэм хэмжээг сааруулах, мэдээллийн аюулгүй байдлыг өндөр хэмжээнд хангахаас бусад тохиолдолд шифрлэх хэм хэмжээг тогтооход зориудаар нөлөөлөхийг оролдохоос зайлсхийвэл зохино. Аль ч засгийн газар шифрийн эрсдэлтэй алгоритм, хэм хэмжээ бий болгох, тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх ёсгүй.

³¹An Open Letter to the Leaders of The World's Governments Signed by Organizations, Companies, and Individuals: We encourage you to support the safety and security of users, companies, and governments by strengthening the integrity of communications and systems. In doing so, governments should reject laws, policies, or other mandates or practices, including secret agreements with companies, which limit access to or undermine encryption and other secure communications tools and technologies. <https://www.securetheinternet.org/>

- Төр, засгаас аливаа аж ахуйн нэгжийг ямарваа нэгэн гэрээний дагуу дээр дурдсан зарчмуудад харшлах үйл ажиллагаа явуулахыг шаардах, үүнд татан оролцуулах ёсгүй.

Иймд интернэтэд иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг хэвлэлийн эрх чөлөөг цагдан хянах, хэт мөрдөн тагнах замаар зөрчиж байгааг зогсоохын тулд дор дурдсан үйл ажиллагааг бүх түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

- Сэтгүүлч, олон нийт нэргүйгээр буюу нэрээ нууцлан мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх, эрх чөлөөг технологийн арга, хэрэгслээр бэхжүүлэх. Үүний тулд мэдээллийг шифрлэх технологи, хэрэгслийг өргөн хүрээнд, тогтмол ашиглах замаар цахим харилцааны аюулгүй байдлыг хангах.
- Төрийн байгууллага, албан тушаалтан цахим орчинд мэдээлэл олж авах эрх, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт бий болгох. Үүний тулд “терроризмтой тэмцэх”, “үндэсний аюулгүй байдлыг хангах” хүрээнд хууль бус, хангалтгүй буюу зохих үндэслэлгүйгээр хэвлэлийн эрх чөлөөг цагдан хянах, хэт мөрдөн тагнахгүй байх, мэдээллийг шифрлэх технологийг ямар нэг байдлаар хязгаарлахгүй байх.
- Хувийн хэвшил, технологийн компаниуд шифрлэх, нэрээ нууцлах эрхийг хязгаарлахтай холбоотой өөрийн бодлогыг өөрчилж, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгчийн нууцлалыг чанд хангах замаар хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах.

1.4. Батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж

1.4.1. ХБНГУ

ХБНГУ “Фрийдом хаус” байгууллагын “Интернетийн эрх чөлөө-2018” тайланд дурдсанаар, 100 орноос 19-рт бичигдэж, “интернетийн эрх чөлөөтэй” оронд тооцогдож байна.³²

Хуулийн нэр: “Нийгмийн хэвлэл мэдээлэлд хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай хууль - Network Enforcement Act (‘NetzDG’), 2017.³³

Зохицуулалт: Энэхүү хуулиар Facebook, YouTube, Twitter болон түүнтэй төстэй нийгмийн хэвлэл мэдээлэл дэх хууль бус агуулга буюу үзэн ядсан үг хэллэг, гүтгэлэг, хуурамч мэдээтэй тэмцэхийг зорьсон байна. Тодруулбал, хууль бус агуулга гэдэгт үзэн ядах (доромжлох, гүтгэх) гэмт хэрэг, гэмт хэргийн шинжтэй хуурамч мэдээ, хүүхдийг садар самуунд ашигласан үйлдэл, терроризмыг сурталчлах агуулга хамаарна. Тус хуульд имэйл, цахим зурвасын үйлчилгээ хамаарахгүй. Нийгмийн хэвлэл мэдээлэл бүр хууль сахиулах байгууллагын хүсэлтэд хариулах чиг үүрэг бүхий дотоодын төлөөлөгч ажиллуулах шаардлагыг хуульчилсан байна.

Үр нөлөө: Тус хуулиар хэрэглэгчийн гомдлыг хүлээн авснаас хойш “илт хууль бус” агуулгыг 24 цагийн дотор нийгмийн хэвлэл мэдээллээс устгах үүрэг хүлээлгэсэн.

³² Freedom on the Net 2018 - Germany. <https://freedomhouse.org/report/freedom-net/2018/germany>

³³ German - Network Enforcement Act (Netzdurchsetzungsgesetz, NetzDG) <https://germanlawarchive.iuscomp.org/?p=1245>

Хэрэв тухайн агуулга хууль бус эсэх нь илэрхий биш бол нийгмийн хэвлэл мэдээллээс 7 хоногийн дотор хянан шалгаж, устгана. Хэрэв нийгмийн хэвлэл мэдээллээс “Өөрийн зохицуулалт бүхий төлөөлөгч” гэж хүлээн зөвшөөрөгдсөн гаднын төлөөлөгчийг хөлсөлж агуулгыг шалгуулж байгаа бол 7 хоногийн хугацаанд сунгаж болно.

Хууль бус агуулгыг тодорхойлохын тулд Эрүүгийн хуулийн холбогдох зүйл буюу хууль бус суртал ухуулгын материал тараах буюу Үндсэн хуульд харшилсан байгууллагын тэмдэглэгээг ашиглах; төрийн эсрэг онц хүнд гэмт хэрэг үйлдэхийг дэмжих; хууран мэхлэх гэмт хэрэг үйлдэхийг завдах; олон нийтийг гэмт хэрэгт уриалах; мөн үзэн ядахыг өөгшүүлэх болон бусад гэмт үйлдлийн зохицуулалтыг хэрэглэнэ. (Хууль бус агуулга гэдэгт ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 86, 86а, 89а, 91, 100а, 111, 126, 129 to 129b, 130, 131, 140, 166, 184b, 184d, 185 to 187, 241, 269 дэх зүйлүүдийг илэрхийлсэн агуулгыг ойлгох талаар тус хуулийн 1 дэх хэсгийн 3-т заасан байна.)

Гомдол гаргах механизм ба хоёр жил тутмын тайлан: Нийгмийн хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд түүний хэрэглэгчид гомдол гаргахад хялбар, ил тод, байнгын механизм бий болгох үүрэгтэй. Мөн тухайн гомдлыг хүлээн авсан, татгалзсан зэрэг шийдвэрийг тухай бүр хэрэглэгчид мэдэгдэх ёстой. Мөн нэг жилийн хугацаанд хууль бус агуулгын тухай 100-аас дээш тооны гомдол хүлээн авдаг нийгмийн хэвлэл мэдээллээс тухайн гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хоёр жил тутам ХБНГУ-ын эрх бүхий байгууллагад тайлагнах шаардлагатай. Энэхүү тайлан нь Холбооны “Төрийн мэдээлэл” эмхтгэл, нийгмийн хэвлэл мэдээллийн нүүр хуудаст хагас жилийн эцсээс хойш нэг сарын дараа нийтлэгдэх ёстой. Тайланд нийгмийн хэвлэл мэдээллийн зүгээс хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээний мэдээлэл, гомдол барагдуулах журам, хүлээж авсан гомдлын тоо, гомдлыг хариуцаж буй ажилтнуудын мэргэжил, тоо, гишүүнчлэл, хууль бус агуулга эсэхийг шийдэхэд гуравдагч этгээдийг оролцуулсан тоо, гомдлын дагуу устгасан агуулгын тоо, агуулга устгахад зарцуулсан хугацаа, гомдол гаргагч болон устгасан агуулгыг нийтэлсэн гишүүнд мэдэгдэл хүргүүлсэн эсэх зэрэг мэдээллийг тусгана.

Үр дагавар:

Дээр дурдсан үүргийг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн нийгмийн хэвлэл мэдээллийн байгууллагыг торгоно. Хэрэв нийгмийн хэвлэл мэдээллээс дотоодын төлөөлөгч ажиллуулаагүй буюу томилогдсон төлөөлөгч нь хүссэн мэдээллийг гаргаж өгөөгүй бол 5 сая хүртэлх еврогоор (ойролцоогоор 5.7 сая ам.доллар) торгоно. Бусад бүх зөрчлийн хувьд, нийгмийн хэвлэл мэдээллийг 50 сая хүртэлх еврогоор торгоно. Хэрэв устгах ёстой хууль бус агуулгыг устгаагүй гэж Хууль зүйн сайд үзэж, компанийг торгохыг хүсвэл энэ тухай шүүхээс шийдвэр гаргуулах ёстой.

1.4.2. Итали

Итали улс “Фрийдом хаус” байгууллагын “Интернетийн эрх чөлөө-2018” тайланд дурдсанаар, 100 орноос 25-рт бичигдэж, “интернетийн эрх чөлөөтэй” оронд тооцогдож байна.³⁴

Хуулийн нэр: Цахим дарамтын эсрэг хууль, 2017.05.17³⁵

Зохицуулалт: Тус хуулийн зорилго нь цахим дарамт буюу цахим орчин дахь зүй бус үйлдлийг тогтоох, тийм үйлдлээс бусдыг, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах, хохирохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах, түүнчлэн цахим орчинд хүчирхийлэл үйлдэгчдийг дахин сурган хүмүүжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Үр нөлөө: Цахим орчин дахь хүчирхийлэлд өртсөн 14-өөс доош насныхан болон тэдний эцэг эх нь өгөгдлийг хянагч буюу вэб сайтын үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо барьж хүчирхийлэл бүхий агуулгыг устгах, блоклох, хаахыг хүсэх, түүнчлэн нэн даруй устгуулах тухай хүсэлт гаргах боломжтой. Өгөгдөл хянагч нь 48 цагийн дотор хохирогчийг хамгаалах, цахим орчин дахь зохисгүй үйлдэл үргэлжлэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л алхмыг хийх үүрэгтэй. Хэрэв энэ үүргээ биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй бол хохирогч, түүний эцэг эх Өгөгдөл хамгаалах чиг үүрэг бүхий төрийн эрх бүхий байгууллагад шууд гомдол гаргаж болно. Өгөгдөл хамгаалах төрийн эрх бүхий байгууллага нь тийнхүү гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор цахим дарамт, цахим орчин дахь зохисгүй үйлдэл бүхий агуулгад тусгай арга хэрэгслээр хөндлөнгөөс нөлөөлөх буюу тийм агуулгыг устгах, хаах эрх хэмжээтэй. Мөн цахим орчин дахь зүй бус үйлдэл гаргажбуй этгээдэд шийтгэл оногдуулах эрх хэмжээг Өгөгдөл хамгаалах чиг үүрэг бүхий төрийн эрх бүхий байгууллагад өгсөн.

Үр дагавар: Энэ хуульд Эрүүгийн хуульд заасан гэмт үйлдлийг цахим орчинд үйлдэх буюу цахим хэлбэрээр үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын хэмжээг Эрүүгийн хуульд зааснаасдордуулахгүй байх талаар заасан. Түүнчлэн, цахим орчинд 14 нас хүрээгүй хүн, түүний гэр бүлийн эсрэг үйлдсэн нэр төр гутаах, заналхийлэх, хууль бус мэдээлэл боловсруулах гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулна. Мөн цахим орчинд хүчирхийлэл үйлдэжбуй насанд хүрээгүй этгээдийн үйлдэлд Эрүүгийн хууль бус энэ хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой болсон.

1.4.3. Австрали

Австрали улс “Фрийдом хаус” байгууллагын “Интернетийн эрх чөлөө-2018” тайланд дурдсанаар, 100 орноос 21-рт бичигдэж, “интернетийн эрх чөлөөтэй” оронд тооцогдож байна.³⁶

1.4.3.1. Хуулийн нэр: Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг бэхжүүлэх тухай 2015 оны хууль, түүний 2017 оны нэмэлт³⁷

³⁴ Freedom on the Net 2018 - Italy <https://freedomhouse.org/report/freedom-net/2018/italy>

³⁵ Italy passes law to fight cyber bullying <https://www.reuters.com/article/us-italy-cyberbullying/italy-passes-law-to-fight-cyber-bullying-idUSKCN18D2GP>

³⁶ Freedom on the Net 2018 - Australia. <https://freedomhouse.org/report/freedom-net/2018/>

Зохицуулалт: Австрали улсад Хүүхдийн цахим аюулгүй байдал хариуцсан комиссар бие даан үйл ажиллагаа явуулж буй нь шинэлэг бөгөөд чухал алхам болжээ. Тус комиссарт цахимхэлбэрээр гомдол гаргах төдийгүй <https://www.esafety.gov.au/> хуудсаар аюулгүй цахим орчин бүрдүүлэхтэй холбоотой бүх талын зөвлөгөө, мэдээлэл авах бүрэн боломжтой байна.

Үр нөлөө: Цахим аюулгүй байдлын комиссар нь бүх Австрали хүний онлайн орчны аюулгүй байдлыг дэмжих үүрэг хариуцлага хүлээнэ. Түүнчлэн, ноцтой цахим гадуурхалд өртсөн өсвөр насны хүмүүсийн гомдлыг хүлээн авч, хууль бус агуулгыг олж тогтоох, устгах, цахим орчин дахь хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

Үр дагавар: Комиссар нь дараах чиг үүрэгтэй.

- (a) Австралийн иргэдийн цахим аюулгүй байдлыг дэмжих;
- (b) Цахим гадуурхал, дарамтын хохирогч болсон Австрали хүүхэд энэ талаар гомдол гаргах системийг удирдах;
- (c) Хүүхдийн цахим аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- (d) 1992 оны Өргөн нэвтрүүлгийн хуулийн дагуу онлайн агуулгын схемийг удирдах.

1.4.3.2. Хуулийн нэр: Эрүүгийн хуулийн нэмэлтийн тухай хууль, 2019.04³⁸ (Хүчирхийллийг илэрхийлсэн материалыг түгээх, дамжуулах) - Criminal Code Amendment (Sharing of Abhorrent Violent Material) Bill 2019,

Зохицуулалт: Эрүүгийн хуулийн нэмэлтээр “хүчирхийллийг илэрхийлсэн материал” буюу террор халдлага, хүний амь хөнөөх, хүчин, хүн хулгайлах үйлдлийг үзүүлсэн материал, дүрс бичлэгийг хориглосон. Нийгмийн хэвлэл мэдээллийн компаниуд ийм материалыг “нэн даруй” устгаагүй тохиолдолд компаний жилийн ашгийнх нь 10% хүртэлх хэмжээгээр торгох, ажилтнуудыг нь 3 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулна. Мөн хууль бус материал илэрсэн, олдсон үед компаниуд цагдаад мэдэгдэх үүрэгтэй.

Үр нөлөө: Хүчирхийллийн зан үйлийн талаар тус хуулийн 474.32-д, хүчирхийллийг илэрхийлсэн материалын талаар тус хуулийн 474.31-д тодорхойлсон бөгөөд “зөвшөөрөл” гэдэг нь сайн дураараа, гаднын нөлөөгүй хийсэн хэлэлцээг хэлнэ гэжээ. Агуулгын үйлчилгээ гэдэг нь Цахим аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасны дагуу олон нийтийн мэдээллийн үйлчилгээ болон интернетийн үйлчилгээг ойлгоно.

Үр дагавар: Технологийн компаниуд, шинжээчдээс боломжгүй гэмээр зүйл шаардаж, үндэстэн дамнасан технологийн хэрэглэгчдийн зан үйлд шийтгэл

³⁷ Australia - Enhancing Online Safety for Children Amendment Act 2017 No. 51, 2017
<https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/105254/128682/F-237304532/AUS105254.pdf>

³⁸ Australia - Criminal Code Amendment (Sharing of Abhorrent Violent Material) Bill 2019
https://parlinfo.aph.gov.au/parlInfo/download/legislation/bills/s1201_first-senate/toc_pdf/1908121.pdf;fileType=application%2Fpdf
[Australia Passes Law to Punish Social Media Companies for Violent Posts
https://www.nytimes.com/2019/04/03/world/australia/social-media-law.html?smid=nytcore-ios-share](https://www.nytimes.com/2019/04/03/world/australia/social-media-law.html?smid=nytcore-ios-share)

оноохыг оролдож буйгаараа ардчилсан нийгэмд харшлах үр дагавартай гэж үзэж байна. Энэхүү хууль нь Австралид төлөөлөгчийн газар, салбаргүй компаниудын эсрэг арга хэмжээ авах нөхцөл болох эсэх нь эргэлзээтэй төдийгүй хууль зүйн маргаантай нөхцөл бий болгож байгаа талаар шинжээчид анхааруулсан байна. Мөн Фэйсбүүк зэрэг олон улсын өндөр ашиг орлоготой компанид ашгаас нь хамаарсан торгууль оногдуулах эрхтэй эсэх зэрэг тодорхойгүй байдлыг бий болгож байна.

1.4.3.3. Хуулийн нэр: Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулийн нэмэлт, 1999

Зохицуулалт: 1999 онд Австрали улсын парламент интернетийн агуулгыг зохицуулахтай холбоотой хууль баталсан. Энэ нь 1992 оны Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулийн нэмэлт хэлбэрээр хуульчлагдсан. Энэхүү зохицуулалт нь интернетийн эрх чөлөө болон олон нийтийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангахад чиглэснээрээ онцлог юм.³⁹ Тодруулбал, тус зохицуулалт нь интернет буюу онлайн үйлчилгээгээр дамжсан, нийтлэгдсэн агуулга нь хүүхдэд тохиромжгүй, хууль бус эсэхийг хянахад чиглэсэн.⁴⁰

Үр нөлөө: Хяналтыг Австралийн өргөн нэвтрүүлгийн эрх бүхий байгууллага (АВА) дараах чиг үүрэгтэйгээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Интернетийн агуулгатай холбоотой гомдлыг хянан шалгах;
- Хүүхэд интернетийг хэрхэн зохистой хэрэглэх зэрэг интернет хэрэглээний аюулгүй байдалтай холбоотой зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд өгөх;
- Интернет хэрэглээний асуудлаар судалгаа хийх;
- Гадаадын холбогдох байгууллагуудтай харилцах.

Мөн тус байгууллага нь Австрали улсад интернетийн агуулга байршуулсан этгээдтэй шууд харилцах замаар хууль бус, хориглосон агуулгыг устгуулах эрхтэй.

Үр дагавар: Мөн Австралийн интернетийн аюулгүй байдлын зөвлөх байгууллага болох NetAlert нь 1999 онд Холбооны Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан. Онлайн агуулгыг бэлтгэх, нийтлэх, хэрэглэхтэй холбоотой асуудлаар олон нийтийг соён гэгээрүүлэх чиг үүрэгтэй бөгөөд гэр бүлд чиглэсэн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл, эх сурвалжаар хангадаг. 1995 онд батлагдсан Ангилал /Хэвлэл, кино, компьютерын тоглоом/-ын тухай хуулийн дагуу боловсруулсан Үндэсний ангиллын дүрэм, ангиллын удирдамжийн дагуу Ангиллын зөвлөл дараах агуулгыг хориотой (RC), насанд хүрэгчдэд зориулсан (X) ангилалд хамааруулсан. Үүнд: Гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхийг харуулсан материал; Хүүхдийн порнограф; Ёс бус бэлгийн харьцаа; Хэт хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлтэй материал; Бэлгийн харилцааны бодит дүрслэл.

³⁹ Jennifer Mullaly. An Overview of Internet Content Regulation in Australia. September 30, 2016 <http://www.tandfonline.com/doi/pdf/10.1080/01296612.2000.11771954?needAccess=true>

⁴⁰ Susan Magnay. Online content regulation. May 2004 <http://www5.austlii.edu.au/au/journals/inCiteALIA/2004/92.pdf>

Дээр дурдсан агуулгын зохицуулалтаас гадна Австрали улсад дараах бусад аргаар агуулгыг зохицуулж байна. Үүнд: Шууд утас ажиллуулах; Шүүлтүүрийн програм хангамж хэрэглэх; Үнэлгээний систем хэрэглэх; Боловсрол олгох; Ухамсар, хандлага төлөвшүүлэх.

1.4.4. БНСУ

БНСУ “Фрийдом хаус” байгууллагын “Интернетийн эрх чөлөө-2018” тайланд дурдсанаар, 100 орноос 36-рт бичигдэж, “интернетийн хагас эрх чөлөөтэй” оронд тооцогдож байна.⁴¹

- Тус улсад Харилцаа холбооны стандартын комиссын шийдвэрээр “North Korea Tech” цахим хуудсыг блоколсон бөгөөд шүүхээс тус шийдвэрийг хууль бус гэж үзсэн.
- Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу, Хойд Солонгостой холбоотой агуулгыг цахим орчинд нийтэлсэн интернэт хэрэглэгч, сэтгүүлчид 1 жил 14 сар хорих ял оногдуулсан.
- 2017 оны 8 дугаар сард шүүхээс тус улсын Үндэсний тагнуулын албаны захирал асаныг “Цахим орчинд бичсэн нийтлэлээрээ тархи угаах замаар 2012 оны сонгуульд нөлөөлсөн” гэж үзэж, 4 жил хорих ял оногдуулсан.
- Харилцаа холбооны стандартын комисс нь “Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний тухай” хуулийн 73 дугаар зүйлийн дагуу хууль зөрчсөн үйлчилгээ үзүүлэгчийг 2 жил хүртэлх хугацаагаар хорих буюу 18 мянган ам.доллараар торгох зохицуулалттай. Мөн “Хүүхэд, өсвөр насны хүнийг хамгаалах тухай” хуулийн 17 дугаар зүйлийн дагуу онлайн үйлчилгээ үзүүлэгч нь хүүхэд оролцуулсан садар самуун агуулгыг устгах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол 3 жил хүртэл хорих, 18 мянган ам.доллараар торгох шийтгэлтэй.
- 2016 оны 3 дугаар сард батлагдсан Терроризмтой тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн дагуу Үндэсний тагнуулын алба нь шүүхийн зөвшөөрөлгүйгээр цахим орчин дахь агуулгыг устгах эрхтэй.

1.5. Гадаад улс, олон улсын байгууллагаас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл

1.5.1. ИБУИНВУ

ИБУИНВУ “Фрийдом хаус” байгууллагын “Интернетийн эрх чөлөө-2018” тайланд дурдсанаар, 100 орноос 23-рт бичигдэж, “интернетийн эрх чөлөөтэй” оронд тооцогдож байна.⁴²

Төслийн нэр: Онлайн орчны аюул заналын талаарх цагаан ном - 2019.04⁴³

⁴¹ Freedom on the Net 2018 <https://freedomhouse.org/report/freedom-net/2018/>

⁴² Freedom on the Net 2018 <https://freedomhouse.org/report/freedom-net/2018/>

⁴³ Websites to be fined over 'online harms' under new proposals <https://www.bbc.com/news/technology-47826946>

Online Harms White Paper, April 2019

https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/793360/Online_Harms_White_Paper.pdf

Боловсруулсан буюу өргөн барьсан этгээд: Дотоод хэргийн яам, Цахим бодлого, соёл, хэвлэл мэдээлэл, спорт хариуцсан хэлтэс.

Зохицуулалт: Нийгмийн хэвлэл мэдээлэл, интернетийн компаниудад зориулсан “үйл ажиллагааны дүрэм” зохион мөрдүүлэх бие даасан зохицуулагчтай болох; зохицуулагч нь дүрэм зөрчсөн компаниудад торгууль оногдуулах эрх хэмжээтэй байх; дүрэм зөрчсөн вэб сайтуудыг блоклох буюу хаахыг интернетийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад даалгах, компанийн гүйцэтгэх удирдлагад торгууль оногдуулах нэмэлт эрх хэмжээтэй байх.

Онлайн орчны аюул занал гэдэгт дараах зүйлийг хамааруулна:

- Цахим орчинд хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, хүчирхийлэх;
- Цахим орчин дахь терроризмын агуулга;
- Хорих газраас хууль бусаар байршуулсан агуулга;
- Мансууруулах бодисын онлайн худалдаа;
- Цахим гадуурхал, дарамт;
- Өөрийгөө гэмтээх, амиа хорлох;
- Бэлгийн дүрслэлийг бага насны хүүхдэд үзүүлэх, дамжуулах;
- Цахим орчин дахь худал мэдээлэл буюу суртал ухуулга;
- Цахим орчин дахь заль мэх /манипуляц/;
- Олны танил, алдартныг доромжлох.

Үр нөлөө: Цахим орчинд компаниуд хэрэглэгчдийнхээ аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авах, гэмт хэрэгтэн, террорист, гадаадын дайсагнасан этгээдийн үйл ажиллагааг цахим орчинд нэвтрүүлэхгүй.

Тус төслийн зөвлөлдөх хэлэлцүүлэг 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс эхэлж, 2019 оны 7 дугаар сарын 01 хүртэл үргэлжлэн, түүнээс хойш 12 долоо хоногийн дараа хаагдсан. Үүний дараа зөвлөлдөх хэлэлцүүлгийн талаарх засгийн газрын хариуг нэгтгэн боловсруулж буй бөгөөд үр дүнг gov.uk цахим хуудаст нийтэлж, цаашид авах арга хэмжээний саналыг нэгтгэн, эцсийн төслийг хууль тогтоох байгууллагад танилцуулна.

Үр дагавар: Өөрийн зохицуулалтыг хязгаарласан.

1.5.2. Европын холбоо

Төслийн нэр: Цахим орчинд терроризмын агуулга тархахаас сэргийлэх тухай төсөл, 2018.09 – Зөвлөлийн гишүүн орнуудын зөвшөөрсөн хувилбар 2018.12⁴⁴

Боловсруулсан буюу өргөн барьсан этгээд: Европын комисс

Зохицуулалт: Энэхүү төслийн зорилго нь олон нийтийн мэдээллийн платформ, мэдээлэл түгээх вэб сайт, хостинг үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс цахим орчин

<https://www.indexonensorship.org/2019/03/uk-government-proposals-to-tackle-online-harms-pose-real-risk-to-online-freedom-of-expression/>

⁴⁴ Proposal for a Regulation on preventing the dissemination of terrorist content online and its fundamental rights implications - Opinion of the European Union Agency for Fundamental Rights

https://fra.europa.eu/sites/default/files/fra_uploads/fra-2019-opinion-online-terrorism-regulation-02-2019_en.pdf

дахь терроризмын агуулгыг устгахад чиглэсэн салбарын хэмжээний тогтвортой арга замыг бий болгоход оршино.

Үр нөлөө: Терроризмын агуулга гэдгийг Европын холбооны 2017/541 тоот Терроризмын талаарх удирдамжид зааснаар тодорхойлсон. Гэхдээ энэ тодорхойлолт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоор хэрэглэсэн тодорхойлолт юм. Цаашилбал, энэ төсөлд зарим ойлголтыг Удирдамжид зааснаас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн. Тухайлбал, “террорист бүлгийн үйл ажиллагааг дэмжих”, “террор үйлдэхэд чиглэсэн арга, техникийг зааварчлах”, “террорист гэмт хэрэг дэх оролцоо” зэрэг ойлголтыг энэхүү төсөлд өргөн хүрээгээр тодорхойлсон. Энэ нь хүний суурь эрхэд хууль бусаар халдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Үр дагавар: Энэхүү төсөлд терроризмын агуулгыг “олон нийт”-д түгээхээс гадна, “гуравдагч этгээд”-д түгээх асуудлыг хамтатган авч үзсэн. Ингэснээр, хувийн харилцаа холбоо буюу имэйл, хувийн зурвас, бусад хэрэглэгчийн үйлчилгээнд нөлөөлөх, хяналт тавих нөхцөлийг бий болгож, хүний эрх, эрх чөлөөнд зохисгүй байдлаар халдах эрсдэлтэй болсон.

1.6. Фэйсбүүк компанийн бодлого, байр суурь

1.6.1. Монгол Улс ба Фэйсбүүкийн харилцаа

Марк Зукербэргийн байгуулсан фэйсбүүк 15 жилийн хугацаанд дэлхийн 2.3 тэрбум гаруй хүнийг хэрэглэгч болгожээ.⁴⁵ Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдлагын урилгаар 2018 оны 9 дүгээр сард Монгол Улсад ажилласан Фэйсбүүк компанийн Ази, Номхон далайн бүсийн орны төлөөлөгчидтэй Цагдаагийн ерөнхий газар уулзалт хийж, тулгамдаад байсан зарим асуудлаар тохиролцсон байна.

Тодруулбал, Фэйсбүүк компани нь хуурамч мэдээлэл, бодит бус хэрэглэгч, зүй бус агуулгыг оновчтой тодорхойлох, ингэснээр зүй бус мэдээллийг устгах, хандалтыг хязгаарлах, түр түдгэлзүүлэх эсхүл хэрэглэгчийн хаягийг хаах ажлыг түргэвчлэхэд туслах зорилго бүхий Ажлын багийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос /ХХЗХ/ бүрдүүлэхээр болжээ. Багийн гишүүд нь Монгол Улсын төрөлх хэл, соёл, үндэсний хэллэгийн онцлогийг мэддэг, англи хэл, салбарын мэдлэгтэй боловсон хүчин байхаар тохирсон байна. Мөн тус компани аливаа гомдол хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай “Green channel” ногоон сувгийг Монгол Улсад нээж өгөхөөр тохиролцсон байна. Ингэснээр Монгол Улсаас энэ сувгаар ирсэн хүсэлтийг шуурхай шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзэж буй аж.⁴⁶

Энэхүү ногоон суваг 2019 оны 6 дугаар сараас эхлэн албан ёсоор ажиллаж эхэлсэн бөгөөд Фэйсбүүк компани нь Монгол Улсын “green channel”-р ирүүлэх гомдол хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэж хариу өгнө. ХХЗХ-ны ажлын баг гомдол, хүсэлттэй холбоотой илүү мэдээлэл цуглуулж, судалгаа хийнэ. Гэхдээ тухайн агуулга нь зөвхөн дараах хүрээнд байна. Үүнд:

⁴⁵ Өнөөдөр Фэйсбүүк 15 нас хүрч байна <https://ikon.mn/n/1hvy>

⁴⁶ Фэйсбүүк компанитай хамтран хуурамч хаяг, мэдээллийг шууд хязгаарладаг болно. 2018.09.13 <https://ikon.mn/n/1ds2>

- Хүчирхийлэл, гэмт хэргийн шинж чанартай
- Олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц
- Амиа хорлолт ба өөрийгөө золиослох
- Хүүхдийн бэлгийн мөлжлөг
- Садар самуун
- Дээрэлхэх ба дарамтлах
- Хувийн мэдээллийн нууцлал
- Үзэн ядах үг хэллэг
- Спам
- Худал мэдээлэл
- Оюуны өмч
- Журамласан бараа бүтээгдэхүүн.⁴⁷

1.6.2. Интернетийг зохицуулах 4 чиглэл

2019.03.30-ны өдөр Фэйсбүүкийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Марк Зукерберг “Интернетийг зохицуулах дөрвөн санаа”-гаа танилцуулжээ.⁴⁸

Тэрээр, Засгийн газар, зохицуулах байгууллагууд илүү идэвхтэй үүрэгтэй байх шаардлагатай гэдэгт итгэж буйгаа онцолж, интернетэд дөрвөн чиглэлээр шинэ зохицуулалт хэрэгтэй байна гэжээ. Үүнд: хортой агуулга, сонгуулийн хараат бус байдал, хувийн нууц – халдашгүй байдал, өгөгдлийн шилжилт хөдөлгөөн.

Нэгдүгээрт, гуравдагч байгууллага нь хортой агуулгыг дамжуулахтай холбоотой баримтлах стандарт тогтоож, түүнийг нь компаниуд зөрчиж буй эсэхийг шалгадаг байж болох юм.

Хоёрдугаарт, бие даасан, чөлөөт сонгуулийг хамгаалахад хууль тогтоомж чухал бөгөөд цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг хариуцах этгээдийг тодорхойлох, нягтлах замаар сонгуульд хөндлөнгөөс зүй бусаар нөлөөлөхийг хязгаарлахад хууль тогтоомж чиглэх ёстой.

Гуравдугаарт, хууль тогтоогчид нууцлал, халдашгүй байдлыг хангах шинэ зохицуулалт бий болгож, олон нийтийн ашиг сонирхлын тулд шинэ технологийн тусламжтайгаар мэдээлэл олж авах, ашиглах нөхцөлийг тодорхой, ойлгомжтой болгох хэрэгтэй.

Дөрөвдүгээрт, өгөгдлийн байршил, хөдөлгөөнийг өгөгдлийн эзэн өөрөө хянах нь чухал. Энэ хүрээнд өгөгдөл, мэдээллийг хамгаалах үүрэг хэнд байхыг тодорхой хуваарилан зохицуулах шаардлагатай.

Эдгээр асуудлын талаарх зохицуулалт нь хувь хүмүүс, компаниуд, Засгийн газруудын үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлоход чиглэх ёстой.

1.7. Зарим орны засгийн газар, нам, эвслээс нийгмийн хэвлэл мэдээллийг хаах, түүнд тархи угаах үйл ажиллагаа явуулж буй байдал

Зарим орны засгийн газар, улс төрийн нам, эвслээс 2016-2018 оны байдлаар нийгмийн хэвлэл мэдээллийг хаах, тасалдуулах явдал эрс нэмэгдэх боллоо.

⁴⁷ Фэйсбүүк болон ХХЗХ-ны хооронд “ногоон суваг” албан ёсоор нээгдлээ. 2019.10.02 <http://crc.gov.mn/k/2Zh>

⁴⁸ “Four Ideas to Regulate the Internet” By Mark Zuckerberg, CEO. March 30, 2019 <https://newsroom.fb.com/news/2019/03/four-ideas-regulate-internet/>

Нийгмийн хэвлэл мэдээллийг хаах, тасалдуулах үндэслэлээ үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, хуурамч мэдээлэл, үзэн ядсан үг хэллэгтэй тэмцэх гэдгээр тайлбарлаж буй боловч, бодит байдал дээр эсэргүүцлийн хөдөлгөөнийг зогсоох, улс төрийн тогтворгүй байдлыг хаацайлах, мэдээллийг хянах, сонгуулийн үйл явцад нөлөөлөх зорилготой байна.⁴⁹



Үүнээс гадна, нийгмийн хэвлэл мэдээлэлд тархи угаах үйл ажиллагаа явуулж буй улсын тоо нэмэгдэж, 70 боллоо. Дэлхийн 26 улсад ийнхүү нийгмийн хэвлэл мэдээлэлд тархи угаахдаа хүний үндсэн эрхийг зөрчих, улс төрийн өрсөлдөгчийг гутаан доромжлох, эсрэг буюу ялгаатай үзэл бодлыг хаах байдлаар нийгэм дэх мэдээллийг хянаж байна.⁵⁰



Энд дурдсан 70 улсын тоонд энэхүү судалгааны 1.4, 1.5 дахь хэсэгт дурдсан ХБНГУ, Итали, Австрали, БНСУ, ИБУИНВУ багтаж байна. Энэ нь нийгмийн хэвлэл мэдээллийг зохих хууль батлах, хэрэгжүүлэхээс гадна хууль хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн зүгээс тогтмол хяналт тавьж байх нь чухал болохыг харуулж байна.

⁴⁹ Access Now. The State of Internet Shutdowns Around the World: The 2018 #KeepItOn Report <https://www.accessnow.org/cms/assets/uploads/2019/07/KeepItOn-2018Report.pdf>

⁵⁰ Samantha Bradshaw, Philip N. Howard. The Global Disinformation Order: 2019 Global Inventory of Organised Social Media Manipulation. 2019 <https://comprop.oii.ox.ac.uk/wpcontent/uploads/sites/93/2019/09/CyberTroop-Report19.pdf>

ХОЁР. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хүрээ, ерөнхий чиглэл

Судалгаанд Ази, Америк, Европын хэвлэл мэдээллийн дөрвөн байгууллагыг хамруулав. Үүнээс ашгийн бус хоёр, тухайлбал Их Британий олон нийтийн өргөн нэвтрүүлгийн корпорац болох *BBC*, *The Associated Press*, мөн *The New York Times*, *Asahi Shimbun* гэсэн хувийн буюу арилжааны хоёр сонин сонгов. Түүнчлэн Бельги, Герман, Дани, Нидерланд, Финландын Хэвлэл мэдээллийн зөвлөлийн туршлагаас орууллаа.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд цахим орчинд өөрийгөө зохицуулах нэгдсэн удирдамж батлан мөрдөж буй нь нэг талдаа байгууллагынхаа нэр хүндийг хамгаалах, нөгөө талдаа иргэдийг төөрөгдүүлэхээс сэргийлэх, мөн сэтгүүлч, сурвалжлагчаа ямарваа гаднын эрсдэлээс хамгаалахад чиглэж байна. Тодруулбал хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт нь дараах зорилготой байна:

- Байгууллагынхаа нэр хүндийг хамгаалах
- Сэтгүүлч, сурвалжлагчаа аливаа эрсдэлээс хамгаалах
- Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах
- Мэдээллийн үнэн, бодит байдлыг баталгаажуулах
- Байгууллагын байр суурь, ажилтны хувийн үзэл бодлыг зааглах
- Уншигч, үзэгчдээ төөрөгдүүлэхээс сэргийлэх
- Бусад хүн, байгууллагын нэр хүндэд халдахаас сэргийлэх
- Ил тод байдлыг хангах
- Хараат бус, бие даасан байдлаа илэрхийлэх, хангах.

Судалгаанд авч үзсэн улс орнуудын Хэвлэлийн зөвлөлөөс баталсан Хэвлэл мэдээллийн нийт ажилтны баримтлах зарчим, мөн тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын дотоод удирдамжийг харвал, өөрийн зохицуулалтын хэм хэмжээ нь доорх хүрээтэй байна. Үүнд:

- Хэрэглэгчийн үүсгэсэн агуулгыг зохицуулах
- Нийгмийн сүлжээний материал ашиглах
- Сэтгүүлчид нийгмийн сүлжээг ашиглах
- Гомдол маргааныг шийдвэрлэх
- Агуулга устгах.

2.1.1. The Associated Press (AP)

The Associated Press бол АНУ-ын Нью-Йорк хотноо төвтэй, хараат бус, ашгийн бус мэдээний байгууллага юм. Дэлхийн 100 гаруй оронд сурвалжлагч, мэдээний багтай. The Associated Press нийгмийн сүлжээ ашиглахтай холбоотой 13 бүлэг бүхий ерөнхий удирдамжийг мөрддөг. Тухайн удирдамж нь нийгмийн сүлжээ, тухайлбал жиргээний орчинд хэрхэн ажиллахад анхаарчээ.⁵¹

⁵¹Social media guidelines for AP employees revised may 2013 https://www.ap.org/assets/documents/social-media-guidelines_tcm28-9832.pdf

Чиглэл	Жишээ
Ил тод байдал Хараат бус, бие даасан байдлаа илэрхийлэх, хангах	<ul style="list-style-type: none"> • Нийтлэл сурвалжлагадаа зориулж бусдын үзэл бодлыг цуглуулах зорилгоор жиргэж, пост хийж байгаа бол тухайн асуудлынхаа бүх өнцөг дээр дуу хоолой сонсохыг хүсэж буйгаа маш тодорхой хэлсэн байх хэрэгтэй.
Байгууллагын нэр хүндээ хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Ажилтнууд нь үзэл бодлоо илэрхийлэхдээ AP-ийн тэнцвэртэй мэдээллийн эх сурвалж гэсэн нэр хүндийг сэвтүүлэх вий гэдгийг үргэлж санаж байх хэрэгтэй. • AP-ийн эзэмшлийн болон нууцлалтай материалыг нийтлэх нь хориотой.
Ажилтнуудаа аливаа эрсдэлээс хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Ажилтнууд нь өөрсдийн талаар эсвэл AP-ийн нэртэй холбогдох хамтран ажиллагсдынхаа талаарх хувийн мэдээлэл, аливаа бодлоо нийтэд дэлгэхдээ бодолтой байх ёстой. Өөрийн хуудсанд нийтлэгдсэн зүйлсээ зөвхөн найзууддаа харагддаг тохиргоотой байсан ч үүнийг мартаж болохгүй. Тиймээс Фэйсбүүкийн тохиргоогоор хэнтэй юу хуваалцах вэ гэдгээ тодорхойлохыг зөвлөж байна. • Ажилтнууд нь бусдынхаа аюулгүй байдлыг эрсдэлд оруулахуйц ямарваа мэдээллийг нийгмийн сүлжээнд нийтэлж үл болно. Тухайлбал, халдлага, хүн барьцаалах гэмт хэргийн эрсдэл дунд сурвалжлага хийж буй сэтгүүлчийн байршлыг зарлах гэх мэт.
Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Магадгүй таны элэглэн шоолж буй хүн эсвэл байгууллага нь хамтран ажиллагсдын чинь хувьд эх сурвалжаа болгохоор хичээж буй нэгэн байж болно.
Мэдээллийн бодит байдлаа баталгаажуулах	<ul style="list-style-type: none"> • Бүх талын байр суурийг илэрхийлэх орон зай хаана байна, тэр бүхэнд AP-ийн хуулбар холбоосыг боломжтой үед оруулна. • Ажилтнууд нь цахим орчин дахь цуурхал түгээхээс ангид байх ёстой. Хэдийгээр үүнийг нь бусад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийтэлсэн ч батлагдаагүй цуурхал түгээж болохгүй. Учир нь AP-ийн ажилтан гэдэг утгаараа тухайн алдаатай мэдээллийг үнэн мэт итгэл төрүүлэхүйц харагдуулж болзошгүй • Нийгмийн сүлжээнд тааралдах аливаа эх сурвалжууд ямар ч баталгаагүй байх бөгөөд бусад төрлийн эх сурвалжтай ажилладагтай адил заавал баталгаажуулах ёстой. • Нийгмийн сүлжээн дэх аливаа зураг, дүрс бичлэг, эшлэлийг тухайн агуулгыг нийтэлсэн хаягийг дурдах маягаар шууд эх сурвалж болгон ашиглаж болохгүй. Заавал эх сурвалжаа баталгаажуулсны дараагаар ашиглана. • Нийгмийн сүлжээнд байгаа аливаа гэрэл зураг, дүрс бичлэг, мультимедиа бүтээлүүдийг өөрийн сурвалжилгадаа ашиглахдаа тухайн агуулгын зохиогчийн эрх эзэмшигчтэй холбогдож заавал зөвшөөрөл авна.
Байгууллагын байр суурь, ажилтны хувийн үзэл бодлыг зааглах	<ul style="list-style-type: none"> • Ажилтнууд нь олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийн үеэр ямарваа асуудлаар байр сууриа илэрхийлэхээс ангид байна. Мөн аливаа учир шалтгаан, хөдөлгөөнийг дэмжих зохион байгуулалттай үйл ажиллагаанд оролцож үл болно. Үүнээс гадна та болон танай хэлтэс тодорхой сэдэв сурвалжилж байгаа эсвэл удирдах албаны хүн нь өөрөө бол жиргэхдээ тэнцвэртэй байдлаа хадгалах тусгай үүрэг хүлээнэ.
Уншигч, үзэгчдээ төөрөгдүүлэхээс сэргийлэх	<ul style="list-style-type: none"> • Ямарваа байдлаар ажилдаа зориулсан бүртгэлээ ашиглаж байгаа тохиолдолд ажилтнууд нь AP-д ажилладаг болохоо илэрхийлэх ёстой. Ажилтнууд нь өөрийн жиргээний хаяг болон хэрэглэгчийн нэрэндээ AP-ийг багтаах шаардлагагүй бөгөөд өөрийн хувийн зургийг л (AP-ийн лого байж болохгүй) ашиглана. Өөрийн танилцуулга хэсэгтээ AP-ийн ажилтан гэдгээ дурдсан байна. • Ажилтнууд нь улс төрийн харьяаллаа өөрийн танилцуулга хэсэгтээ багтаахгүй бөгөөд улс төрийн байр сууриа илэрхийлсэн ямар нэгэн нийтлэл хуваалцах ёсгүй. • Улс төрийн нэр дэвшигчтэй найз болж “like” дарах нь нийгмийн сүлжээний ерөнхий үйл ажиллагааны талаар мэдлэггүй хүмүүсийн дунд буруу ойлголт төрүүлж мэднэ. Тиймээс аливаа маргаантай

	<p>асуудлууд дээр аль аль талыг нь төлөөлөх хүмүүстэй холбоо тогтоохыг оролдох нь зүйтэй. Мэдээний гол субъект болдог хүмүүстэй олон нийтийн хуудсаар нь дамжуулж сэтгэгдэл үлдээх зэргээр харилцахаас зайлсхийх ёстой. Ажилтнууд нь өөрсдийн хүсэлтээ илгээгүй тохиолдолд AP-ийн удирдлагууд ажиллагсад уруугаа найзын хүсэлт илгээж болохгүй.</p> <ul style="list-style-type: none"> • Ажилтнууд нь ямарваа баталгаагүй цуурхал, хов живийг дахин жиргэхээс ангид байх ёстой.
<p>Бусдын нэр хүнд, байгууллагын нэр хүндэд халдахаас сэргийлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Заримдаа AP-ийн ажилтнууд нь олон нийтийн хэвлэл мэдээллийн орчин дахь спорт болон энтертэйнмент чиглэлийн асуудлууд дээр сэтгэгдэл үлдээхэд чөлөөтэй юу гэж асуух нь бий. Мэдээж хариулт нь тийм, гэхдээ зарим чухал асуудлуудыг санаж байх шаардлагатай юм: Нэгт, хэн нэгний (нэр хүндтэй хүн, баг, компани) талаар доромжлон гутааж ярих нь ажилтнууд болон байгууллагад муугаар тусах болно. Таны жиргээ нь сэтгэгдлийн үндсэн зорилгоороо бусдад харагддаг болохыг ойлгоно уу.

Жишээ: The Associated Press дараах зүйлийг ажилтнууддаа удирдамж болгожээ.⁵²

- Нэг л нийгмийн сүлжээнд бүртгүүл. Ингэхдээ өөрийгөө сэтгүүлч гэдгээ ил хэлж, ажилладаг байгууллагынхаа нэрийг тодорхой тавь.
- Өөрийн танилцуулга, тодорхойлолт(profile)-д улс төрийн хандлагаа бүү бич. Улс төрийн үзэл бодлоо, эсвэл редакцын хараат бус байдалд нөлөөлөхүйц пост бүү тавь.
- Хараал, доромжлолын өнгө аяс бүхий сэтгэгдэл бүү постол.
- Ямар мэдээллийг хэнтэй солилцохоо тогтоож, нууцлалаа тохируул.
- Нийгмийн сүлжээний мэдээг бүү тасалдуул. Яаралтай мэдээ тавих хэрэг гарвал редактортаа хэлж, шалгуул.
- Эх сурвалжаа нягтал. Нийгмийн сүлжээнд тухайн хүн хэн бэ гэдгийг тодорхойлох нь ярвигтай ч ямар нэг суурь мэдээлэл заавал байдаг.
- Нийгмийн сүлжээний гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглахдаа зохиогчийн эрхийг зөрчихгүй байх буюу зохиогчийн нэрийг бичих, хаанаас авснаа эшлэх.
- Хэрэглэгчийн хариулт, санал гомдлыг ажиглан, редактортаа тайлагнаж бай. Нийгмийн сүлжээний сэтгэгдлүүд, зурвас нь хувийн шинж чанартай яриа мэт боловч маргаан үүссэн тохиолдолд редактор түүнд хариу өгөх нь зүйтэй.

2.1.2. BBC

BBC буюу Их Британий өргөн нэвтрүүлгийн корпорац нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл бөгөөд олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг. Эднийх нийт 18 үндсэн бүлэг бүхий “Үйл ажиллагааны удирдамж”-ийг даган мөрдөж байна. Мөн нэг давуу тал нь олон улсын болон үндэсний хэмжээний томоохон үйл явдлын хүрээнд сурвалжилга бэлтгэхдээ тухайн үйл явдалд зориулсан үйл ажиллагааны тусгай удирдамж баталж, мөрддөг ажээ.⁵³

Би Би Си (BBC) Нийгмийн хэвлэл мэдээллийн удирдамждаа дараах асуудлыг голлон анхаарсан байна.⁵⁴

⁵²AP’s Social Media Guidelines for AP Employees https://www.ap.org/assets/documents/social-media-guidelines_tcm28-9832.pdf

⁵³Editorial Policy Guidance notes supplement the Editorial Guidelines, with further explanation of their themes and practical tips <https://www.bbc.com/editorialguidelines/guidance>

⁵⁴ BBC. Guidance: Social media <https://www.bbc.com/editorialguidelines/guidance/social-media>

- БиБиСигийн ба ажилтны нийгмийн хэвлэл мэдээллийн бүх үйл ажиллагаанд нэгдсэн удирдамж баримтлах.
- Нийгмийн хэвлэл мэдээлэлд мэргэжлийн болон хувийн үйлдэлд ялгамжгүйгээр сэтгүүл зүйн мэргэшсэн байдлыг хадгалах
- Нийгмийн хэвлэл мэдээллийн төрөл, хэлбэрээс үл хамааран сэтгүүл зүйн мэргэшсэн байдлыг хадгалах
- Нийгмийн хэвлэл мэдээлэл дэх аливаа мэдээлэл, нийтлэлдээ хүүхэд, эмзэг бүлгийнхнийг эрсдэлд оруулахгүй байх, тэднийг хамгаалах, үүний тулд няхуур байх
- БиБиСигийн ажилтан нь нийгмийн хэвлэл мэдээлэл дэх үйлдлээрээ БиБиСигийн нэр хүндийг унагахаас зайлсхийх.

Чиглэл	Жишээ
Ил тод байдал Хараат бус, бие даасан байдлаа илэрхийлэх, хангах	<ul style="list-style-type: none"> • Редакцид харьяалагдан ажилладаг хүмүүс нь өөрийн улс төрийн үзэл баримтлалаа илэрхийлэх ёсгүй. Редакцын бус ажилтнуудын хувьд улс төрийн үйл хэрэгт оролцох гэж байгаа тохиолдолд өөрсдийн үүрэг оролцоог ил тод болгох ёстой.
Байгууллагын нэр хүндээ хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Блог, микроблог болон хувийн цахим хуудсандаа ВВС-ийн ажилтан гэдгээ танилцуулаагүй тохиолдолд ВВС-ийн талаар ярилцаж болохгүй бөгөөд цэвэр хувийн асуудлууд нь удирдамжаас ангид байна. • Нийгмийн сүлжээнд ил болгож буй мэдээллүүд нь ВВС-ийн нэр хүндийг харлуулахгүй байх тал дээр анхаарч байх ёстой.
Ажилтнуудаа аливаа эрсдэлээс хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Интернэт орчинд тавигдсан материалыг дахин ашиглах нь эрх зүйн талаасаа хувийн нууц болон зохиогчийн эрхийн асуудал үүсгэж болзошгүй • ВВС-ийн ажилтан нь хувийн шугамаар интернэт ашиглахдаа болзошгүй зөрчилдөөнийг үүсгэх магадлалаас өөрийгөө холдуулж байх ёстой.
Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Олон нийтийн мэдэх ёстой зарим мэдээллүүд нь зөвхөн нэрээ нууцалсан эх сурвалж, хувь нэмрээ оруулагчдаар дамжих тохиолдол бий. Бид тухайн эх сурвалжийг татан оролцуулахдаа нэрийг нь нууцлахаа амласан үед өөрсдийн хүрээний амлалтаа заавал биелүүлэх ёстой.
Мэдээллийн бодит байдлаа баталгаажуулах	<ul style="list-style-type: none"> • Интернэтийн орчинд байгаа зурагнуудыг юу эсвэл хэнийг хэрхэн харуулж буйгаар нь шууд хүлээж авч болохгүй. Нягт нямбай байдлын үүднээс заавал баталгаажуулж бай. • Хэдийгээр нийгмийн хэвлэл мэдээлэл болон хувийн цахим хуудсанд тавигдсан зургуудыг ашиглахад хялбар боловч эмзэг байдлыг нь харгалзан үзэх үүргийг үгүйсгэхгүй. Мөн тухайн зургийн зорилгоос шалтгаалан олон нийтийн эрх ашгийн үүднээс тэнцвэртэй байдлаа хадгална. • Тухайн нийтлэлийн гол зорилго нь юу байсан бэ? тухайн зураг нь хувийн цахим хуудас, нийгмийн сүлжээнд тавигдсан нь эзэмшигчийн талын зорилгын хүрээнд ашиглагдаж байгаа гэсэн үг биш байж болохыг ойлгоно уу.
Байгууллагын байр суурь, ажилтны хувийн үзэл бодлыг зааглах	<ul style="list-style-type: none"> • ВВС-ийн цахим сүлжээн дэх хуудас болон хувийн шугамаар ашиглах цахим хуудаснуудын хооронд ил тод зааг байх ёстой. • Өргөн нэвтрүүлэг, цахим мэдээллийн эх сурвалж, ач холбогдол бүхий хувь нэмэр оруулсан хүмүүсийнхээ нэрийг тавьж, танилцуулж байх ёстой. Ингэснээр үзэгч, уншигчид өөрсдийн дүгнэлтээ хийж чадах болно.
Уншигч, үзэгчдээ төөрөгдүүлэхээс сэргийлэх	<ul style="list-style-type: none"> • Аливаа мессежийг цааш дамжуулах эсвэл дахин жиргэхдээ тодорхой үзэл бодлыг ВВС баталгаажуулж буй мэт харагдуулахгүй байхад анхаарах ёстой.

Бусдын нэр хүнд, байгууллагын нэр хүндэд халдахаас сэргийлэх	<ul style="list-style-type: none"> • Бидний бүтээлүүд нь ямар нэгэн хувь хүн, эсхүл байгууллагыг буруутай, шударга бус үйлдлүүд, эсхүл чадваргүй байдалд буруутгаж байгаа бол тус асуудлын хүрээнд хариу тайлбар хийх боломжийг тухайн буруутгагдаж буй талд заавал олгоно.
--	--

Жишээ(Зүйл 7.4.8)⁵⁵:

Нийгмийн сүлжээний материал (хувийн цахим хуудас), ялангуяа эмгэнэлтэй, дарамттай гонсойлгом үйл явдлыг харуулсан гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглахдаа үр нөлөөг нь авч үзэх.

- Нягт нямбай эсэхийг нягтлах
- Тэнцвэрт байдал
- Анхны санаа зорилго ямар байсан
- Хууль бус, нийгмийн эсэрэг үйл ажиллагаа
- Хувийн нууц, зохиогчийн эрх

2.1.3. The New York Times(The Times)

The New York Times сонин Нью-Йорк хотноо байрладаг, 1951 онд байгуулагдсан. Хэвлэлтийн тоогоороо Америктаа гуравдугаарт, дэлхийд 18-рт ордог. The Times харьяа редакциудынхаа бүх хэлтэс, албад нь нэгдсэн байдлаар мөрддөг “Нийгмийн хэвлэл мэдээллийн удирдамж” баталсан байна. Олон улсын хэвлэл мэдээллийн бусад агентлагийг бодвол энэхүү тусгай удирдамж нь харьцангуй цомхон.⁵⁶

Чиглэл	Жишээ
Ил тод байдал Хараат бус, бие даасан байдлаа илэрхийлэх, хангах	<ul style="list-style-type: none"> • Манай сэтгүүлчид нийгмийн хэвлэл мэдээллийн нийтлэлүүдэд нэг талыг барьсан үзэл бодол илэрхийлэх, улс төрийн өнцөг сурталчлах, нэр дэвшигчийг дэмжих, түрэмгий сэтгэгдэл бичих эсвэл The Times-ийн сэтгүүл зүйн нэр хүндийг унагах аливаа үйлдэл хийж үл болно.
Байгууллагын нэр хүндээ хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Манай сэтгүүлчдийн бүх төрлийн нийгмийн хэвлэл мэдээллийн орчинд хийж буй аливаа үйлдэл нь энэхүү удирдамжид хамаарна. Хэдийгээр Facebook хуудас, Twitter, Instagram, Snapchat бусад нийгмийн мэдээллийн хаягууд нь өөрийн хувийн орон зай гэж үзэж болох ч бидний нийтлэл эсвэл “like” бүр нь ямар нэгэн байдлаар олон нийтийн хүртээл болж байдаг. Энэ ч утгаараа цахим орчин дахь аливаа үйлдэл тань The Times-тай холбогдож ойлгогддог.
Ажилтнуудаа аливаа эрсдэлээс хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн хэвлэл мэдээллийн орчинд хэн нэгэн өөрийг тань заналхийлж буй мэт санагдвал нэн даруй дээд албан тушаалтандаа мэдэгдэнэ үү. Бид сэтгүүлчдийнхээ аюулгүй байдлыг хамгаалах өөрийн бодлоготой.
Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах	<i>Үндсэн ёс зүйн удирдамж болон стандартдаа тусгасан</i>
Мэдээллийн бодит байдлаа баталгаажуулах	<i>Үндсэн ёс зүйн удирдамж болон стандартдаа тусгасан</i>
Байгууллагын байр	<ul style="list-style-type: none"> • Манай сэтгүүлчид The Times-ийн бодитоор сурвалжилж буй

⁵⁵ <http://www.bbc.co.uk/editorialguidelines/page/guidance-social-media-pictures>

⁵⁶The Times Issues Social Media Guidelines for the Newsroom
<https://www.nytimes.com/2017/10/13/reader-center/social-media-guidelines.html>

суурь, ажилтны хувийн үзэл бодлыг зааглах	аливаа асуудлууд дээр аль нэг талыг барьж буй мэт харагдахгүй байхад онцгой анхаарах ёстой.
Уншигч, үзэгчдээ төөрөгдүүлэхээс сэргийлэх	<ul style="list-style-type: none"> Зарим тохиолдолд бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээг Times-ийн сурвалжлагч жиргэхэд тухайн мэдээг Times баталгаажуулсан мэтээр тайлбарлагдах нь бий.
Бусдын нэр хүнд, байгууллагын нэр төрд халдахаас сэргийлэх	<i>Үндсэн Ёс зүйн удирдамж болон стандартдаа тусгасан</i>

2.1.4. Asahi Shimbun

Asahi Shimbun сонин Япон улс даяар өдөрт 7 сая орчим хувь хэвлэгдэн борлуулагддаг, тухайн орондоо төдийгүй бүсийн хэмжээнд өөрийн гэсэн нэр хүндээ тодорхойлсон хэвлэл мэдээллийн салбарын томоохон тоглогчдын нэг юм. Тус сонин 2015 оны гуравдугаар сарын нэгнээс нийгмийн хэвлэл мэдээллийн зохицуулалтын удирдамж батлан, даган мөрдөж байна.⁵⁷

Чиглэл	Жишээ
Ил тод байдал Хараат бус, бие даасан байдлаа илэрхийлэх, хангах	<ul style="list-style-type: none"> Asahi Shimbun-ий сурвалжлагчид нь ёс зүйн өндөр мэдрэмжтэй байх бөгөөд өөрийн болон байгууллагын шударга байдалд халдах мэдээлэл түгээж болохгүй
Байгууллагын нэр хүндээ хамгаалах	<ul style="list-style-type: none"> Asahi Shimbun-ийн энэхүү удирдамж нь сонины сурвалжлагчдын хувийн болон нээлттэй бүх аккаунтуудад ч даган мөрдөгдөнө.
Ажилтнуудаа аливаа эрсдэлээс хамгаалах	<ul style="list-style-type: none"> Оюуны өмчийн эрхийг зөрчиж үл болно. Үүнд Asahi Simbun-ийн оюуны өмч ч хамаарна.
Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах	<ul style="list-style-type: none"> Аливаа нууц эх сурвалжаас олж авсан мэдээлэл, ярилцлага өгч буй хүнтэй тогтоосон итгэлцэлтэй холбоотой агуулгыг үл нийтэлнэ
Мэдээллийн бодит байдлаа баталгаажуулах	<ul style="list-style-type: none"> Хэрэв нийтэлсэн мэдээлэл нь алдаатай бол нэн даруй засварлах, шаардлагатай тохиолдолд хүлцэл өчих хэрэгтэй.
Байгууллагын байр суурь, ажилтны хувийн үзэл бодлыг зааглах	<ul style="list-style-type: none"> Сэтгүүлчдийн хувийнхаа аккаунтаар түгээсэн мэдээлэл нь Asahi Shimbun-ийн албан ёсны байр суурь биш болно.
Уншигч, үзэгчдээ төөрөгдүүлэхээс сэргийлэх	<ul style="list-style-type: none"> <i>The Yomiuri Code буюу Ёс зүйн кодоор зохицуулагдана</i>
Бусдын алдар хүнд, нэр төр болон байгууллагын нэр төрд халдахаас сэргийлэх	<ul style="list-style-type: none"> Хувийн мэдээллийг нийтэд дэлгэхүйц мэдээллийг үл түгээнэ. Бид аливаа хувь, компани, бүлгийг доромжлох зорилготой мэдээлэл үл түгээнэ.

2.2. Хэвлэлийн зөвлөлийн үүрэг, оролцоо

Технологи хөгжихийн хэрээр нийтлэл, өгүүлэл, дуу дүрсэд суурилсан мэдээлэл байршуулах, хуваалцах, түгээх талбар, суваг, боломж өргөссөн нь

⁵⁷Asahi Shimbun editorial department social media guidelines
https://translate.googleusercontent.com/translate_c?depth=1&hl=en&prev=search&rurl=translate.google.com&sl=ja&sp=nmt4&u=http://www.asahi.com/twitter/guideline.pdf&xid=25657,15700023,15700186,15700191,15700256,15700259&usq=ALkJrhgsQjAVibbrWwYzkmrfv_DbR17WQ

уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд хэрэглэгчдийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа улам сайжруулах хэрэгцээ шаардлага бий болгожээ.

Олон улсын хэмжээнд албан ёсны өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэлийн зөвлөл, Хэвлэл мэдээллийн зөвлөлийг хүлээн зөвшөөрч, эрх зүйн хүрээнд ч баталгаажуулдаг. Өөрийн зохицуулалтын нэгдсэн байгууллага нь сэтгүүл зүйн мэргэжлийн ба ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх, хараат бус, шударга байдлыг хангах үүрэгтэй. Үүний тулд тухайн улс орондоо нийтээр дагаж мөрдөх Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг батлан мөрдөж, иргэдийн санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг.

Тухайлбал, Финландын Хэвлэл мэдээллийн ажилтнуудын удирдамжид⁵⁸ 2001 оны 9-р сарын тавны өдөр цахим хэвлэл мэдээлэлтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар оруулжээ.

- Редакц цахим хуудаастаа мониторинг хийж, хувийн нууц, хүний эрхэм чанарыг хөндөж, зөрчсөн агуулгаас сэргийлэхийг эрмэлзэнэ. Ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг өөгшүүлсэн, хувь хүн, бүлэг этгээдийг үзэн ядсан-агуулгыг устгана.
- Хүүхэд, залуучуудад чиглэсэн онлайн форумд тогтмол мониторинг хийнэ.

Бельгийн Сэтгүүл зүйн зөвлөлөөс гаргасан Хэвлэл мэдээллийн удирдамжид хэрэглэгчийн үүсгэсэн агуулгыг устгах тухай заалт бий. Зүй бус агуулгыг аль болох түргэн, цаг алдалгүй устгах ба дараах аргыг ашиглана. Үүнд:

- Хэрэглэгчдийг урьдчилан бүртгэх
- Ашиглалтын нөхцөл, шаардлагыг сайтдаа ойлгомжтой байршуулах
- Хэлэлцүүлгийн (форум) үеэрх зүй зохисгүй хариу үйлдэлд тайлбар өгөх.⁵⁹

Нидерландын Хэвлэлийн зөвлөлийн удирдамжийг гишүүд нь 2007 онд баталсан бөгөөд 2008, 2010, 2015, 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нидерландад Воркинк хэмээх сэтгүүлчийн хэрэг нь энэ чиглэлд тодорхой жишиг тогтоосон байна. Тэрээр хувийн бодлоо бичээд “РТВ-гийн мэдээг үзээрэй” гэжээ. Үүний дараа сэтгүүлчдийг Twitter-т жиргэхийг “хувь хүний бус сэтгүүлчийн үйл ажиллагаа” гэж үздэг болсон байна. Мөн зүй бус жиргээг уншигдахгүй болгохыг шаарддаг ажээ.⁶⁰

Ардчилсан нийгэмд ямар ч иргэн хэвлэл мэдээллээр өөрийнх нь тухай гарсан мэдээлэлд хариу өгөх эрхтэй. Ардчиллын соёл төлөвшсөн улс орнуудад шинэ нөхцөл байдалд тохируулан өөрийн зохицуулалтын байгууллагууд түргэн шуурхай хариу үйлдэл хийж, дүрэм журамдаа өөрчлөлт хийж эхэлсэн билээ. Тухайлбал, Данийн Хэвлэлийн зөвлөлийн шүүн таслах эрх хэмээх Данийн Хэвлэл мэдээллийн хариуцлагын дүрмийн нэгдүгээр бүлэгт зааснаар, мэдээний цахим

⁵⁸Council for Mass Media. Guidelines for Journalists and an Annex http://www.jasn.fi/en/guidelines_for_journalists/

⁵⁹Guidelines of the Code of Practice of the Council for Journalism https://rvdj-my.sharepoint.com/personal/rvdj_rvdj_onmicrosoft_com/Documents/Documents/Code%20RvdJ/Code%20website-Engels-2018.pdf?&originalPath=aHR0cHM6Ly9ydmRqLW15LnNoYXJlcG9pbmQuY29tLzpiOi9nL3BlcnNvbWFsL3J2ZGpfcjZkal9vbm1pY3Jvc29mdF9jb20vRWRhSTNTZ3R4WjIGZ2t5NTY5ZTFndmNCVXRGOtk4ME9XbEIPQzBhUkVUaFpPZz9ydGltZT0tU0dzbnBwTTEwZw

⁶⁰Guidelines of the Netherlands Press Council. 2018 <https://www.rvdj.nl/english/guidelines>

хуудас, мэдээний агентлаг, гар утасны сонин, ярьдаг сонин зэрэг Хэвлэл мэдээллийн зөвлөлд бүртгэлтэй цахим системтэй холбоотой гомдол маргааныг хүлээн авч шийдвэрлэнэ⁶¹

ХБНГУ-ын Хэвлэлийн зөвлөл Гомдол, маргаан шийдвэрлэх журмынхаа “Гомдол гаргах эрх” хэмээх нэгдүгээр зүйлд⁶² дор дурдсан байдлаар нэмэлт өөрчлөлт хийжээ.

- Сэтгүүл зүй, редакцын агуулга бүхий мэдээлэл ба тэрхүү хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаар гомдол гаргах эрхтэй.
- Хувийн мэдээллийг сэтгүүл зүй, редакцын агуулгад ашигласан нь өгөгдлийг хамгаалах эрхийг зөрчсөн гэж үзсэн бол гомдол гаргах эрхтэй.

Монгол Улсад 2015 онд Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулагдсан. Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолоор Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим баталсан юм. 2019 оны 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногт болсон Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүх гишүүдийн хоёр өдрийн сургалт, хэлэлцүүлгийн үеэр хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд “10. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ” гэж нэмэлт оруулсан. Ингэснээр Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим 10 заалттай болжээ. Түүнчлэн Хэвлэл мэдээллийн зөвлөлийн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар сонгуулийн үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөл хэрхэн ажиллах дүрэм журмыг хэлэлцэж, гомдол хүлээж авах, барагдуулах журамдаа нэмэлт оруулж, олон нийтэд танилцуулах шийдвэр гаргасан.⁶³

⁶¹The Press Ethical Rules <https://www.pressnaevnet.dk/press-ethical-rules/>

⁶²German Press Code. Guidelines for journalistic work as recommended by the German Press Council; Complaints Procedure <https://www.presserat.de/files/presserat/dokumente/download/Press%20Code.pdf>

⁶³ХМЗ-ийн бүх гишүүдийн сургалтаар хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд нэмэлт заалт орууллаа. 2019.05.09 <http://www.mediacouncil.mn/a/3>

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

3.1. Нийгмийн хэвлэл мэдээллийг хууль тогтоомжоор зохицуулж буй байдал

Энэ судалгааны хүрээнд нийгмийн хэвлэл мэдээллийг зохицуулахтай холбоотой урьд батлагдсан, тодорхой хугацаанд хэрэгжсэн хууль төдийгүй батлагдаад удаагүй хууль тогтоомжийн талаар авч үзэв. Үүнээс гадна, зохицуулалтын шинэ төслийг шинжлэн судлав.

Дээрх хууль тогтоомжийн хувьд, цахим орчинд хяналт тавих эрх бүхий, бие даасан байгууллага байгуулах, түүний чиг үүргийг өргөн хүрээнд тогтоох нөхцөл нийтлэг байна. Ингэхдээ, эрх бүхий этгээд буюу зохицуулагчийн үйл ажиллагааг тусгайлсан хуулиар тогтоох, эрүүгийн хуульд нэмэлт оруулах хэлбэрээр бэхжүүлж байна. Энэхүү эрх бүхий этгээдийн үйл ажиллагааны үр нөлөөг хангах үүднээс нийгмийн хэвлэл мэдээллийн эрхлэгч, компаниудад үүрэг оногдуулах, торгууль оногдуулах бүрэн эрхийг хуулиар олгож байна.

Гэхдээ зохицуулалтын зүйл буюу цахим агуулгын төрөл, хэлбэрийг харилцан адилгүй байдлаар, ихэвчлэн өргөн хүрээнд тодорхойлж буй нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдал бий болгох, цахим орчны хэрэглэгчийн эрх, эрх чөлөөнд хөндлөнгөөс зохисгүй байдлаар халдах эрсдэл бий болгож байна.

Нийгмийн хэвлэл мэдээллийннөлөө бүхий компани болох Фэйсбүүкийн үзэж буйгаар, Засгийн газар, зохицуулах байгууллагууд илүү идэвхтэй үүрэгтэй байх шаардлагатай бөгөөд интернетийг хортой агуулга, сонгуулийн хараат бус байдал, хувийн нууц – халдашгүй байдал, өгөгдлийн шилжилт хөдөлгөөн гэсэн дөрвөн чиглэлээр шинэ зохицуулалт хэрэгтэй байна. Энэ нь цаашид цахим орчинд төрийн үүрэг, оролцоо нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

Иймд Монгол Улсад цахим орчныг зохицуулахдаа цахим орчин дахь хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байхад онцгой анхаарч, дараах шалгуураар хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

- Цахим орчинд аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хэрэглэгчдэд зориулсан мэдлэг олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг цахим орчныг зохицуулах хууль тогтоомжийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгох;
- Цахим орчинд эрх нь зөрчигдсөн буюу тийнхүү зөрчигдөх бодит эрсдэлтэй хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, шалган шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох;
- Цахим орчин дахь илт хууль бус агуулгыг хэт өргөн хүрээнд бус, тодорхой, хоёрдмол утгагүйгээр, нэг мөр ойлгож хэрэглэх боломжтой байдлаар тусгайлан тодорхойлох;
- Цахим орчин дахь илт хууль бус агуулгыг арилгах, тийм агуулгаас сэргийлэх үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчих нөхцөл болох ёсгүйг онцгойлон анхаарч зохицуулах.

- “Терроризмтой тэмцэх”, “үндэсний аюулгүй байдлыг хангах” хүрээнд хууль бус болон зохих үндэслэлгүйгээр хэвлэлийн эрх чөлөөг цагдан хянах, иргэдийн захидал харилцааг хэт мөрдөн тагнахгүй байх, мэдээллийг шифрлэх технологийг ямар нэг байдлаар хязгаарлахгүй байх нөхцөлийг заавал тусгах.
- Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн Газар, Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос хэвлэл мэдээллийн мэргэжлийн эвлэл холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран тоон бичиг үсгийн сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах

3.2. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт

Судалгааны хүрээнд цуглуулсан мэдээллээс харахад, хэрэглэгчдийнхээ өмнө хариуцлага хүлээх, тэдний итгэл даах, нийгэмд нэр хүндтэй байж зөвшөөрөгдөх хүсэл зориг бүхий хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн зохицуулалтын зарчим, хэм хэмжээг дотооддоо боловсруулан нийгмийн хэвлэл мэдээлэлтэй харилцах удирдамжаа батлан мөрдөж байна. Нийгмийн сүлжээний хэрэглээтэй холбоотой өөрийн зохицуулалтын удирдамж нь сэтгүүлч, сурвалжлагч, ажилтан, албан хаагчдаа аливаа эрсдэлээс хамгаалахад чиглэжээ.

Иргэдийн итгэлийг даах, хадгалах нь сэтгүүл зүйн үндсэн тулгуур багана юм. Үүнийг ардчилсан хэвлэл мэдээллийн, хоточ нохойн үүргийн гол цөм гэж болно. Иргэдийн эрх ашигт үйлчилдэг, хараат бус байдлаа үнэт зүйл, эрхэм зорилго болгосон улс оронд Хэвлэлийн зөвлөл нь тэргүүлэх үүрэгтэй байгааг судалгаанаас харж болно. Иймээс манай мэргэжлийн сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийнхэн судалгаанд хамрагдсан байгууллагуудын жишгээр нийгмийн хэвлэл мэдээлэлтэй харилцах редакцын удирдамжтай байх, нийт хэвлэл мэдээллийн дагаж мөрдөх ёс зүйн зарчимд энэ тухай тусган хэрэгжүүлэх нь улс төр, нийгмийн өндөр ач холбогдолтой.

Иймд дор дурдсан зүйлийг Зөвлөмж болгож байна. Үүнд:

- Мэргэжлийн сэтгүүл зүй эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллага бүр Нийгмийн хэвлэл мэдээллийн суваг ашиглах удирдамж боловсруулж батлах, мөрдөх
- МСНЭ гишүүдийнхээ Ёс зүйн зарчим, нийгмийн сүлжээ ашиглах удирдамж боловсруулан батлах, мөрдүүлэх, гишүүддээ, мөн энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн бусад мэргэжилтнүүдэд зориулсан тогтмол сургалт зохин байгуулах
- Сэтгүүлчдийн эвлэл холбоод, хэвлэл мэдээллийн төрийн бус байгууллага, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран Нийгмийн сүлжээ ашиглах стратеги бодлого боловсруулах
- Нийгмийн хэвлэл мэдээлэл ашиглах редакцын удирдамж, дүрэм журмын хэрэгцээ шаардлагын талаар хэвлэл мэдээллийнхний дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, сургалт хийх, ийм бодлого, журамтай дотоодын хэвлэл

мэдээллийн байгууллагуудын туршлагаас хуваалцах зэргээр ач холбогдлыг нь ухамсарлуулан ойлгуулах

- Монголын Хэвлэлийн зөвлөл санаачлан хэвлэл мэдээллийн бусад төрийн бус байгууллагатай хамтран үлгэрчилсэн дүрэм, удирдамж боловсруулах
- Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн Газар, Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хэм хэмжээ боловсруулах, Үлгэрчилсэн удирдамж боловсруулах, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан сургалт хийхэд дэмжлэг үзүүлэх.

ЭХ СУРВАЛЖ

А. Монгол хэлээр:

1. Харилцаа холбооны зохицуулах хороо. Монгол Улсын харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд. <http://crc.gov.mn/k/2Us>
2. ЦЕГ-ын статистикийн тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээ, 2018
3. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016. Улаанбаатар. 2017
4. УИХ-ын Байнгын хороо: Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийв. 2019.04.23 <http://parliament.mn/n/4fco>
5. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Харилцаа холбооны зохицуулах хороо. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааны тайлан. 2017 он. <http://forum.parliament.mn/projects/458>
6. Ikon.mn сайтын редакцын бодлого <https://ikon.mn/policy#p5>

Б. Гадаад хэлээр:

1. “Four Ideas to Regulate the Internet” By Mark Zuckerberg, CEO. March 30, 2019 <https://newsroom.fb.com/news/2019/03/four-ideas-regulate-internet/>
2. “Keystones to foster inclusive Knowledge Societies: Access to information and knowledge, Freedom of Expression, Privacy, and Ethics on a Global Internet”. Final study. Published in 2015 by the United Nations Educational, Scientific and Cultural Organization 7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France p.17 <http://unesdoc.unesco.org/images/0023/002325/232563E.pdf>
3. 2015 Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression A/HRC/29/32 http://www.ohchr.org/EN/HRBodies/HRC/RegularSessions/Session29/Document/s/A.HRC.29.32_AEV.doc.
4. 2016 World Press Freedom Index by Reporters Without Borders, April 20, 2016 <https://rsf.org/en/ranking>; <https://rsf.org/en/mongolia>; <https://rsf.org/sites/default/files/carte-classement-mondial-de-la-liberte-de-la-prese-2016.pdf>
5. Agenda, World Press Freedom Day in Helsinki on May 3rd 2016, Plenary 1: Protecting your rights: Surveillance Overreach, Data Protection, and Online Censorship. p.9 http://www.unesco.org/new/fileadmin/MULTIMEDIA/HQ/CI/CI/pdf/WPFD/Agenda_WPFD2016_Full_Online.pdf
6. An Open Letter to the Leaders of The World’s Governments Signed by Organizations, Companies, and Individuals: We encourage you to support the safety and security of users, companies, and governments by strengthening the integrity of communications and systems. In doing so, governments should reject laws, policies, or other mandates or practices, including secret agreements with companies, which limit access to or undermine encryption and other secure communications tools and technologies. <https://www.securetheinternet.org/>
7. Australia - Criminal Code Amendment (Sharing of Abhorrent Violent Material) Bill 2019 https://parlinfo.aph.gov.au/parlInfo/download/legislation/bills/s1201_first-senate/toc_pdf/1908121.pdf;fileType=application%2Fpdf

8. Australia - Enhancing Online Safety for Children Amendment Act 2017 No. 51, 2017 <https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/105254/128682/F-237304532/AUS105254.pdf>
9. Australia Passes Law to Punish Social Media Companies for Violent Posts <https://www.nytimes.com/2019/04/03/world/australia/social-media-law.html?smid=nytcore-ios-share>
7. Concept Note: Access to Information and Fundamental Freedoms This Is Your Right! World Press Freedom Day 3 May 2016 http://www.unesco.org/new/fileadmin/MULTIMEDIA/HQ/CI/CI/pdf/WPFD/WPFD2016_Concept-Note.pdf
10. Freedom on the Net 2018 - Germany. <https://freedomhouse.org/report/freedom-net/2018/>
11. German - Network Enforcement Act (Netzdurchsetzungsgesetz, NetzDG) <https://germanlawarchive.iuscomp.org/?p=1245>
12. International Covenant on Civil and Political Rights /Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2200A (XXI) of 16 December 1966 entry into force 23 March 1976, in accordance with Article 49/ <http://www.ohchr.org/en/professionalinterest/pages/ccpr.aspx>
13. Italy passes law to fight cyber bullying <https://www.reuters.com/article/us-italy-cyberbullying/italy-passes-law-to-fight-cyber-bullying-idUSKCN18D2GP>
14. Jennifer Mullaly. An Overview of Internet Content Regulation in Australia. September 30, 2016 <http://www.tandfonline.com/doi/pdf/10.1080/01296612.2000.11771954?needAccess=true>
8. Joint Declarations of the representatives of intergovernmental bodies to protect free media and expression. Ed. by Adeline Hulin. - Vienna: OSCE Representative on Freedom of the Media, 2013. p.22-23. <http://www.osce.org/fom/99558?download=true>
9. How Countries Are Regulating Internet Content. Peng Hwa Ang Nanyang Technological University Singapore. https://www.isoc.org/inet97/proceedings/B1/B1_3.HTM
10. Necessary and Proportionate: International Principles on the Application of Human Rights to Communications Surveillance with Background and Supporting International Legal Analysis. Published by the Electronic Frontier Foundation. 2015
15. Online Harms White Paper, April 2019 https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/793360/Online_Harms_White_Paper.pdf
16. Proposal for a Regulation on preventing the dissemination of terrorist content online and its fundamental rights implications - Opinion of the European Union Agency for Fundamental Rights https://fra.europa.eu/sites/default/files/fra_uploads/fra-2019-opinion-online-terrorism-regulation-02-2019_en.pdf
11. Protecting Press Freedom from censorship and Surveillance Overreach. World Press Freedom Day-3 May. 2016.04.22 <https://www.facebook.com/notes/world-press-freedom-day-3-may/protecting-press-freedom-from-censorship-and-surveillance-overreach/1005552352813635>
12. Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, 22 May 2015. <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G15/095/85/PDF/G1509585.pdf?OpenElement>

13. Resolution adopted by the General Assembly on 18 December 2013 68/167. The right to privacy in the digital age
http://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/68/167
17. Susan Magnay. Online content regulation. May 2004
<http://www5.austlii.edu.au/au/journals/inCiteALIA/2004/92.pdf>
14. The Right to Privacy in the Digital Age
<http://www.ohchr.org/EN/Issues/DigitalAge/Pages/DigitalAgeIndex.aspx>
15. Travel Guide to the Digital World: Surveillance and International Standards by Michael Karanicolas. London. 2014. p. 46
18. UK government proposals to tackle online harms pose real risk to online freedom of expression
<https://www.indexonensorship.org/2019/03/uk-government-proposals-to-tackle-online-harms-pose-real-risk-to-online-freedom-of-expression/>
16. UN Human Rights Committee's General Comment 34 on Article 19 of the International Covenant on Civil and Political Rights (ICCPR), p. 3, 4, 11
<http://www2.ohchr.org/english/bodies/hrc/docs/gc34.pdf>
17. Universal Implementation Guide for the International Principles on the Application of Human Rights to Communications Surveillance. A Product of ACCESS. May 2015. Accessnow.org
https://en.necessaryandproportionate.org/files/2016/04/01/implementation_guide_international_principles_2015.pdf
19. Websites to be fined over 'online harms' under new proposals
<https://www.bbc.com/news/technology-47826946>
20. Японы сонин, нийтлэгч, сэтгүүлчдийн холбооны үндсэн цахим хуудас
<https://www.pressnet.or.jp/english/about/canon/#canon2>
21. Хонконгийн хэвлэл мэдээллийн зөвлөлийн үндсэн цахим хуудас
<https://www.hkja.org.hk/en/code-of-ethics/code-of-ethics-of-hkja/>
22. Мэргэжлийн сэтгүүлчдийн нийгэмлэгийн үндсэн цахим хуудас
<https://www.spj.org/ethicscode.asp>
23. АНУ-ын хэвлэлийн холбооны үндсэн цахим хуудас
<https://uspressassociation.org/page.php?57>
24. Олон улсын сэтгүүлчдийн сүлжээнээс гаргасан нийгмийн сүлжээ ашиглах удирдамж
<https://ijnet.org/en/resource/social-media-journalists-basics>
25. Huffington Post-ийн нийтлэл Social Media vs. Social Networking
https://www.huffpost.com/entry/social-media-vs-social-ne_b_4017305
26. Social media guidelines for ap employees revised may 2013
https://www.ap.org/assets/documents/social-media-guidelines_tcm28-9832.pdf
27. Social Media and Third Party Websites, Use of Pictures from: Summary and Guidance in Full
<https://www.bbc.co.uk/editorialguidelines/guidance/social-media-pictures>
28. Online, Social Media and Audience Contributions
29. <https://www.bbc.co.uk/editorialguidelines/guidelines/appendix8/online#heading-61-use-of-social-media>
30. The Times Issues Social Media Guidelines for the Newsroom
<https://www.nytimes.com/2017/10/13/reader-center/social-media-guidelines.html>
31. Asahi Shimbun editorial department social media guidelines
http://www.asahi.com/twitter/guideline.pdf&xid=25657,15700023,15700186,15700191,15700256,15700259&usq=ALkJrhgsqQjAVibbrWwYzkmrfv_DbR17WQ
32. The history of social media and its impact on business
https://www.researchgate.net/profile/Simeon_Edosomwan/publication/303216233_The_history_of_social_media_and_its_impact_on_business/links/57fe90ef08ae56fae5f23f1d/The-history-of-social-media-and-its-impact-on-business.pdf

33. What's the difference between social media and new media

<https://medium.com/@cspenn/whats-the-difference-between-social-media-and-new-media-71f7f5ae1eea>